

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 7625 дугаарт бүртгээ

ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар А/90

Улаанбаатар
хот

ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, 18.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү үнэлгээний үзүүлэлтийг үндэслэн эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах дээд боловсролын сургалтын байгууллага, музейг тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Отгонцэцэг)-т даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны “Үнэлгээний үзүүлэлт батлах тухай” 463 дугаар тушаал, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны “Үнэлгээний үзүүлэлт шинэчлэн батлах тухай” А/34 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ж.ЭНХБАЯР

*Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны
5 дугаар сарын 20-ны өдрийн А/90 дүгээр тушаалын хавсралт*

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, МУЗЕЙГ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЗЭРЭГЛЭЛД ХАМААРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлэх ажлыг зохион байгуулах, дүгнэх, үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2.Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах шалгуурыг хангасан байгууллага нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд эрдэм шинжилгээний байгууллагын статустайгаар оролцоно.

1.3.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18.2.2, 18.2.6-д тус тус заасан байгууллагыг тухайн байгууллагын хүсэлтэд үндэслэн үнэлгээнд хамруулна.

1.4.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.4.1.“дээд боловсролын сургалтын байгууллага” гэж Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1дэх хэсэгт заасныг;

1.4.2.“музей” гэж Музейн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасныг.

1.5.Хүсэлт гаргасан байгууллага нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.5.1.Байгууллагын үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, технологийн урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх;

1.5.2.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлд төрөөс баримталж байгаа бодлого, зорилтыг хангахад чиглэгдсэн байх.

Хоёр.Үнэлгээний үзүүлэлт

2.1.Дээд боловсролын сургалтын байгууллагыг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт (сүүлийн 3 жилийн дунджаар):

| № | Үнэлгээний үзүүлэлтийн нэр | Босго үзүүлэлт | Тооцох аргачлал (нотлох баримт бичиг) |
|---|--|---|---|
| 1 | Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байгаа багш нарын хувь | ≥50 | Үндсэн багшийн “Б цаг” буюу эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлээр тооцно (үндсэн багшаар ажиллуулах ректорын тушаал, Б цагийн төлөвлөгөө баталсан тушаал, гүйцэтгэл тооцсон баримт бичиг). |
| 2 | Нийт багш нарын дотор доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь | ≥40 | Тухайн байгууллагад ажиллаж буй нийт үндсэн багшаас доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувиар тооцно (цалин, нэмэгдэл тогтоосон захирамжлалын баримт бичиг). |
| 3 | Нийт суралцагчдын дотор магистрант, докторантын эзлэх хувь | ≥20 | Бүртгэлтэй суралцагчдын тоогоор тооцно (Элссэн тухай тушаал, цахим системийн бүртгэл). |
| 4 | Магистрант, докторантын дотор эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэгчийн эзлэх хувь | ≥30 | Магистрт суралцагчдын хувьд “Судалгааны магистр”-ыг тооцно. “Мэргэжлийн магистр”-ыг тооцохгүй (Элссэн тухай тушаал, цахим системийн бүртгэл). |
| 5 | Нийт орлогод судалгаа хөгжүүлэлтийн ажлын орлогын эзлэх хувь | ≥10 | Бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөрийн орлого, тэдгээрийн шугамаар үндсэн хөрөнгөд бүртгэсэн хөрөнгө оруулалтыг тооцно (тухайн оны санхүүгийн аудитлагдсан тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэл). |
| 6 | Шинжлэх ухааны холбогдох чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх эрдэм шинжилгээний лабораторийн хангамж | Шинжлэх ухааны холбогдох чиглэл бүрээр төрөлжсөн лабораторитой байх | Байгууллагын бүтцийг баталсан баримт бичгээр тооцно. |
| 7 | Эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний бүтээл, сэтгүүл | Шинжлэх ухааны холбогдох чиглэл бүрээр | Тухайн байгууллагын албан ёсны, тогтмол хэвлэлээр тооцно. |
| 8 | Хэвлүүлсэн нийт эрдэм шинжилгээний өгүүллээс олон улсад хэвлэгдсэн өгүүллийн эзлэх хувь | ≥10 | Шпрингер нэйчур (Springer Nature)-ын Даймэнешнз (Dimensions) олон улсын мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн тооцно. Дээрх мэдээллийн санд хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээлийг тооцож болно. |

| | | | |
|----|---|---|---|
| 9 | Нийт оюуны өмчид аж үйлдвэрийн өмчийн эрх авсан бүтээлийн эзлэх хувь | ≥10 | Зөвхөн тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй оюуны өмчийг тооцно. |
| 10 | Нийт судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнгээс үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтэрч, ашиглагдсан бүтээлийн эзлэх хувь | ≥10 | Дараах ажлыг гэрээгээр тооцно: 1.Нийт судалгаа хөгжүүлэлтийн төсөл, хөтөлбөрөөс хувийн хэвшлийн захиалгаар гүйцэтгэж буй ажлын эзлэх хувь; 2.Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнгээс Лицензийн гэрээгээр дамжуулсан ажлын эзлэх хувь. |
| 11 | Эрдэмтэн, багш нарын эрдэм шинжилгээний хурал, семинар | Тусгай хөтөлбөрөөр тогтмол зохион байгуулдаг байх | Арга хэмжээний тайлангаар тооцно. |
| 12 | Нэг багшид ноогдох эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй зардал (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон) | х6 | Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан нийт зардал, үүнд судалгаа, хөрөнгө оруулалт зэргийг тооцно (тухайн оны санхүүгийн аудитлагдсан тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэл). |
| 13 | Нэг багшид ногдох эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажлын орлого (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон) | х4 | 5-д заасан орлогыг нийт үндсэн багшийн тоонд харьцуулан тооцно (тухайн оны санхүүгийн аудитлагдсан тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэл). |

2.2.Музейг эрдэм шинжилгээний байгууллын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт (сүүлийн 3 жилийн дунджаар):

| № | Үнэлгээний үзүүлэлтийн нэр | Босго үзүүлэлт | Тооцох аргачлал |
|---|--|--|--|
| 1 | Музейн сан хөмрөгийг иж бүрдүүлэх, үзмэрт түшиглэсэн судалгаа явуулах, баяжуулах, сэргээн засварлах, ашиглах, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгох, тэдгээрийн гарал үүсэл, үнэ цэнийг тогтоох чиглэлээр дангаараа буюу эрдэм шинжилгээний холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх судалгаа хөгжүүлэлтийн ажил | 3-с доошгүй судалгаа хөгжүүлэлт-ийн ажлыг тогтмол гүйцэтгэдэг байх | Бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөрийг тооцно (тухайн оны санхүүгийн аудитлагдсан тайлан, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр). |

| | | | |
|---|---|--|--|
| 2 | Үзмэрийн тодорхойлолтын бүрдэл | Үзмэрийн сан хөмрөгийн 60-аас доошгүй хувьд нь шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, мэдээлэл бий болгосон байх | Нийт үзмэрт “шинжлэх ухааны бүрэн тодорхойлолттой үзмэр”-ийн эзлэх хувиар тооцно (Сан хөмрөгийн нэгдсэн бүртгэл). |
| 3 | Нийт ажиллагчдын дотор эрдэм шинжилгээний ажилтан (судалгааны ажилтан)-ы эзлэх хувь | ≥10 | Бүтэц, албан тушаал баталсан тушаал, томилсон тушаалаар тооцно. |
| 4 | Судалгааны ажилтны дотор магистр, доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй ажилтны эзлэх хувь | ≥20 | Үндсэн албан хаагчдаас тооцно. |
| 5 | Эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны ном, товхимол, гарын авлага | 2-оос доошгүй нэр төрөл | Тухайн байгууллагын албан ёсны, тогтмол хэвлэлээр тооцно. |
| 6 | Тухайн музейн жилийн төсөвт эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн зардлын эзлэх хувь | ≥10 | Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан нийт зардал, үүнд судалгаа, хөрөнгө оруулалт зэргийг тооцно (тухайн оны санхүүгийн аудитлагдсан тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэл). |
| 7 | Эрдмийн зөвлөл | Зөвлөлтэй байх | Эрдмийн зөвлөлийг баталсан тушаал байна. |

Гурав.Үнэлэх үйл ажиллагаа

3.1.Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулна.

3.1.1.Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг, улсын стратегийн онцгой салбар болон үндэсний өв соёл, шашны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд холбогдох бусад хууль, журмыг үнэлгээнд харгалзан үзэж болно.

3.2.Ажлын хэсэг нь эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэл тогтоологохоор хүсэлт гаргасан байгууллагыг “Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт”-ийг “хангасан”, “хангаагүй” эсэхэд дүгнэлт гаргана.

3.3.Үнэлгээний нийт үзүүлэлтийн 70 хувийн шаардлагыг бүрэн хангасан байгууллагыг эрдэм шинжилгээний зэрэглэлд хамруулна.

3.4. Үнэлгээний үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд хүсэлт гаргагчид Ажлын хэсгээс гарсан дүгнэлтийг хүргүүлнэ. Энэ нь тус дүгнэлтийг үндэслэн хүсэлтээ дахин хүргүүлэх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

3.5. Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дээд боловсролын сургалтын байгууллагыг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах шийдвэрийг гаргана.

3.6. Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээ хийх үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/144

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9, 11.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг зохицуулалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдэд даалгасугай.

3.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газар (Б.Артур), хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 154 дүгээр тушаалын 08 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 25-ны
өдрийн А/144 дүгээр тушаалын хавсралт*

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН ЗУРМАГ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлд шинжилгээ хийх, зурмагт өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулахдаа аливаа этгээдэд давуу эрх олгохгүй, өрсөлдөөнийг хязгаарлахгүй, харилцан уялдаатай, нэгдмэл системтэй байх зарчмыг баримтална.

1.3.Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд төрийн байгууллага, олон нийтийг зохих мэдээллээр хангаж ажиллана.

1.4.Хөдөлгөөний нэгдсэн зурмагийг төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцогчид дагаж мөрдөнө.

1.5.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар хэрэглэнэ.

1.6.Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг гэдгийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 4.1.18-д зааснаар ойлгох бөгөөд дараах байдлаар ангилна.

1.6.1.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг;

1.6.2.төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг (цаашид “суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг” гэх);

1.6.3.төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний хоногийн төлөвлөгөөт зурмаг (цаашид “хоногийн төлөвлөгөөт зурмаг” гэх);

1.6.4.төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмаг (цаашид “галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмаг” гэх).

1.7.Нэгдсэн технологийн горим нь Монгол Улсын төмөр замын сүлжээнд ачаа болон зорчигч тээвэрлэлт, галт тэрэг болон сэлгээний хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалт, техник ашиглалт, засвар

үйлчилгээ, аюулгүй ажиллагааг бүхэлд нь ханган зохицуулахад чиглэгдсэн хүний үйл ажиллагаанд суурилсан үйлдлүүдийн цогцолбор, ажиллагааны дарааллыг тогтооно.

Хоёр. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах

2.1. Төрийн захиргааны байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горимыг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг үндэслэн боловсруулж, батална.

2.2. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, Төмөр замын тээврийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам болон дараах шаардлагад нийцсэн байна.

2.2.1. төмөр замын суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн горим болон төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд байгуулсан гэрээнд нийцсэн байх;

2.2.2. төмөр замын тээх болон нэвтрүүлэх чадварыг хамгийн өндөр бүтээмжтэй ашиглах, засвар, үйлчилгээний төлөвлөгөөтэй уялдуулсан байх;

2.2.3. хөдлөх бүрэлдэхүүнийг өндөр бүтээмжтэй ашиглах боломжоор хангасан байх;

2.2.4. төмөр замын тээврийг хилийн боомтын үйл ажиллагаа болон бусад төрлийн тээвэртэй уялдуулсан байх;

2.2.5. төмөр замын тээвэрлэлтийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдийн санал, хүсэлтийг судлан, харгалзан үзсэн байна.

2.3. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчээс хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгуулах саналаа төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд дараах материалыг хавсаргана. Үүнд:

- суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн төсөл;

- суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн төсөлд тусгуулахаар тээвэрлэгч болон бусад үйлчлүүлэгч этгээдээс ирүүлсэн зорчигч, ачаа тээвэрлэлтийн захиалга, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлбар;

- зэргэлдээ төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчтэй галт тэрэг солилцох (хүлээлгэн өгөх буюу хүлээн авах), хөдлөх бүрэлдэхүүн, нэвтрүүлэх зорчигч, ачааны боломжит дээд хэмжээний тухай санал, түүний үндэслэл, тооцоо, судалгаа, технологийн горимд орсон өөрчлөлт, бусад баримт.

2.4. Төрийн захиргааны байгууллага нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийг үндэсний аюулгүй байдал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, Олон улсын төмөр замын харилцааны зорчигч, ачаа тээвэрлэлт болон улс орны эдийн засаг, нийгэмд

онцгой ач холбогдолтой зарим төрлийн ачааны тээвэрлэлт, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, тээвэрлэгчдийн ашиг сонирхол зэрэг шалтгаанаар тээвэрлэлтийн үйл ажиллагаа, галт тэрэгний аяллын мөрний хуваарилалтад хуульд заасан үндэслэлээр аливаа хязгаарлалт, давуу эрх, дараалал тогтоох харилцааг холбогдох олон улсын болон үндэсний гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журамд нийцүүлэн боловсруулан баталж, мөрдүүлж ажиллана.

2.5. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, тэдгээртэй хамааралтай мэдээллийг цуглуулахад төмөр замын тээвэрлэлтийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдийн гаргасан санал, зөвлөмжийг нээлттэй хүлээн авна.

2.6. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн өөрийн төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсруулж, батална.

2.7. Суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсруулахад дараах шаардлагыг хангасан байна.

2.7.1. суурь бүтэц дэх тээвэрлэлтийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээд нь суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгуулах (тээвэрлэлт хийлгэх) саналаа тээвэрлэгчдэд бичгээр гаргах бөгөөд дараах материалыг хавсаргасан байна. Үүнд:

-тээвэрлэлтийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдийн хүсэлт;

-тээвэрлэлттэй холбоотой гэрээ, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн гэрээний хуулбар;

-иргэний үнэмлэхийн хуулбар (зөвхөн иргэнд хамаарна);

-аж ахуйн нэгж, байгууллагын хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар байна.

2.7.2. тээвэрлэгч нь суурь бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгуулах тээвэрлэлтийн хэмжээний талаарх саналаа энэхүү журмын 4.2.1-д заасан хугацаанд хүргүүлсэн байна;

2.7.3. төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулахдаа ачааны захиалга, тээвэрлэлтийн хэмжээ нь суурь бүтцийн хүчин чадлаас давсан тохиолдолд олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн дамжин өнгөрөх, экспорт, импорт, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой ачаа зэргээс бусад ачааг захиалгат хэмжээнээс үл хамааран өөрийн суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадварт тохируулан, шударга өрсөлдөөнийг ханган тээвэрлэсэн байхаар зурмагт тусгасан байна.

2.8.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, тэдгээрт өөрчлөлт оруулах явц болон хөдөлгөөний нэгдсэн зурмагийн хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, шийдвэрлүүлнэ.

Гурав.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах

3.1.Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулахгүй. Харин төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмагт зөвхөн дараах тохиолдолд өөрчлөлт оруулж болно.

3.1.1.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн тээх, нэвтрүүлэх чадал нэмэгдсэн, шинэ техник технологи нэвтрүүлсэн;

3.1.2.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарьт өөрчлөлт орсон;

3.1.3.тээвэрлэх ачааны хэмжээнд өөрчлөлт оруулсан;

3.1.4.шинээр өртөө, зөрлөг ашиглалтад оруулсан, өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийгдсэн.

3.2.Галт тэрэгний хөдөлгөөний хоногийн төлөвлөгөөт зурмагт суурь бүтэц эзэмшигчийн ээлжийн галт тэрэгний хөдөлгөөний ахлах диспетчер нь хөдөлгөөн хариуцсан нэгжийн даргатай зөвшилцөж, өөрчлөлт оруулж болно.

3.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний баталсан зурмагт өөрчлөлт оруулж баталснаас ажлын 5 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хувийг ирүүлнэ.

3.4.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах явц, түүнтэй хамааралтай мэдээллүүд нь энэхүү журмын 2.5-д заасны адил хүрээнд нээлттэй байна.

Дөрөв.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн цаглавар

4.1.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг зуны ба өвлийн цагийн гэж хуваана.

4.2.Суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг дараах цаглаварын дагуу боловсруулж, батална.

4.2.1.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэнээс зуны цагийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг жил бүрийн 03 дугаар сарын 05-ны дотор, өвлийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг 09 дүгээр сарын 05-ны дотор авах ба санал авах тухай 21-ээс доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана;

4.2.2.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгуулахаар ирүүлсэн саналыг нэгтгэн, суурь бүтэц дэх зуны цагийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор, өвлийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг 09 дүгээр сарын 25-ны дотор боловсруулна;

4.2.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зуны зурмагийн төслийг 03 дугаар сарын 31-ний дотор, өвлийн зурмагийн төслийг 10 дугаар сарын 01-ний дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

4.2.4.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь нэгдсэн зурмаг батлагдсанаас хойш 10 хоногийн дотор өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг баталж мөрдөнө.

4.3.Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг дараах цаглаврын дагуу боловсруулж, батална.

4.3.1.Төрийн захиргааны байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгуулахаар ирүүлсэн төслүүдийг нэгтгэн, зуны хөдөлгөөний нэгдсэн зурмагийг жил бүрийн 04 дүгээр сарын 20-ны дотор, өвлийн хөдөлгөөний нэгдсэн зурмагийг 10 дугаар сарын 20-ны дотор боловсруулж, батална;

4.3.2.хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Тав.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх

5.1.Төрийн захиргааны байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх бөгөөд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран зурмагийн шинжилгээг гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд удирдамжийг баталж, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид албан бичгээр хүргүүлнэ.

5.2.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь зурмагийн гүйцэтгэлийн шинжилгээнд зориулагдсан дараах баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад гаргаж өгнө.

5.2.1.шинжилгээнд хамрагдах хугацааны суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний хоногийн ажлын төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн зурмагууд;

5.2.2.ачааны вагоны паркийн хоногийн тайлан;

5.2.3.шаардлагатай тохиолдолд суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн төлөвлөлтийн болон диспетчерийн шуурхай тушаал;

5.2.4.техникийн нормчлол, түүний гүйцэтгэлийн тайлан;

5.2.5.бусад баримт бичиг.

5.3.Төрийн захиргааны байгууллага нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийн биелэлт болон суурь бүтцийн ашиглалтын ажлын чанарын үзүүлэлтүүдийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, тайланг гарган нэгтгэж хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах талаар төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нарт үүрэг, даалгаврыг албан бичгээр хүргүүлж биелэлтийг хангуулж ажиллана.

5.4.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь төрийн захиргааны байгууллагаас өгсөн үүрэг, зөвлөмжийн дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба биелэлтийг хугацаанд нь тус байгууллагад хүргүүлнэ.

Зургаа.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих

6.1.Хөдөлгөөний нэгдсэн зурмагаар тухайн төмөр замын суурь бүтцээр аялах болон суурь бүтэц хооронд солилцох галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэх зорчигч, ачааны төлөвлөгөөт хэмжээ, галт тэрэгний аяллын хурд, хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн ашиглалтын ажлын үзүүлэлтүүдийг тодорхойлно.

6.2.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү журмын 2.2-д нийцүүлэн өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, хоногийн төлөвлөгөөт зурмагийг тус тус боловсруулан баталж, хэрэгжүүлэн галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмагийг хөтөлнө.

6.3.Хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгасан замналын галт тэрэгний аяллын мөрийг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжид заасан гэрээний дагуу тээвэрлэгчид ашиглуулна.

6.4.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг болон тээвэрлэгчтэй байгуулах тээвэрлэлтийн гэрээг Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журамд хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн боловсруулж, зохион байгуулан, мөрдүүлэн ажиллана.

6.5.Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний аяллын мөрийг аливаа этгээдэд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд давуутай байдлаар ашиглахгүй.

Тайлбар: Энэхүү журмын 6.5 дахь заалт нь өөрийнх нь хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

6.6.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, хоногийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн зурмагийн биелэлтэд хийсэн шинжилгээ болон зурмагийн тасалдлын мэдээг төрийн захиргааны байгууллагад “Төмөр замын тээврийн мэдээлэл солилцох, бүртгэх журам”-д заасан хугацаанд, тогтоосон маягтын дагуу хүргүүлнэ.

6.7.Нэгдсэн технологийн горимын биелэлтэд төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

Долоо.Хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2.Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн тасалдал, түүний хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

7.3.Суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд байгуулсан гэрээнд зурмагийн тасалдлын хохирлыг тооцохтой холбоотой асуудлыг тусгана.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар А/73

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 8 дугаар зүйлийн 8.4, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.15, 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн байгууллага, зураг төслийн байгууллагуудад даалгасугай.

4.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, техник технологи, судалгааны газар (Л.Булганхүү)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРТУР

*Төмөр замын газрын даргын 2026 оны
5 дугаар сарын 21-ний өдрийн
А/73 дугаар тушаалын хавсралт*

**ТӨМӨР ЗАМЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ,
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛ ХИЙХ, ТЕХНИК,
ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмаар улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөх, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, зураг төсөл боловсруулах, эдгээрийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь хүрээлэн буй орчин болон газар орны нөхцөлд зохицож байгаа эсэх, хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдал нь төмөр замын норм норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд зөвлөмж, санал дүгнэлт гаргах, магадлал хийх болон Зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Төмөр замын тээврийн тухай хуулийн 21.1-д заасан төмөр замын суурь бүтцийн зураг төсөл, 4.1.9-д заасан салбар замын зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм ба дүрмийн шаардлагад нийцүүлсэн байх бөгөөд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэсэн байна.

1.3. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) нь энэхүү журмын 1.2-д заасан зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох ба шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн, Магадлалын ерөнхий дүгнэлт гаргах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр баригдах төмөр замын зураг төслийг гадаадын хуулийн этгээд боловсруулах тохиолдолд Төмөр замын тээврийн тухай хуулийн 21.2-т заасны дагуу Монгол Улсын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй хамтран монгол хэлээр гүйцэтгэсэн байна.

1.5. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналт (цаашид “техник, технологийн хяналт” гэх)-ыг Төмөр замын тээврийн тухай хуулийн 22.2-т заасны дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллага, Захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

1.6.Техник, технологийн хяналтад төмөр замын суурь бүтэц барих, өргөтгөх ажлыг магадлагдсан төмөр замын суурь бүтцийн зураг төсөл, төсөв, суурь норм, стандарт, дүрэм, журам, техникийн баримт бичгийн дагуу чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн түвшинд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зэрэг Зөвлөх үйлчилгээ хамаарна.

ХОЁР. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

2.1.Техник, эдийн засгийн үндэслэл нь тухайн төслийг хэрэгжүүлэх боломж, үр ашиг, хэрэгцээ шаардлага, зардал, үр дүнг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлж, дүгнэсэн баримт бичиг байна.

2.2.Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад дараах зарчмыг баримтална:

2.2.1.шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, дүгнэлт, тооцоолол, шийдэл нь бодит мэдээлэл, судалгаа, тоон үндэслэлд тулгуурласан байх;

2.2.2.байршил, эрэлт хэрэгцээ, техник, технологи, байгаль орчны мэдээлэл нь баталгаатай эх сурвалжтай, иж бүрэн, цогц байдлыг хангасан байх;

2.2.3.санхүүгийн болон нийгэм, эдийн засгийн үр өгөөж, үр ашгийн тооцоонд үндэслэн ашигтай хэрэгжих эсэхийг дүгнэсэн байх;

2.2.4.бүтэц, аргачлал, тооцоолол нь Монгол Улсын хууль, тогтоомж, норм, норматив, дүрэм, журам, техникийн зохицуулалт, үндэсний стандарттай нийцсэн байх;

2.2.5.төлөвлөлтийн үе шатанд орон нутаг, оролцогч талуудын саналыг тусгах, эрсдэл, нөлөөлөл бүхий асуудлыг нийтийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэсэн байх;

2.2.6.байгаль орчинд ээлтэй, эрчим хүч, усан хангамж болон бусад байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, ногоон хөгжлийн бодлогод нийцсэн байх;

2.2.7.суурь бүтцийн чиг, байршлийг хэд хэдэн хувилбараар боловсруулж, тэдгээрийг техник, технологи болон эдийн засгийн үзүүлэлтээр харьцуулан үнэлж, хамгийн оновчтой хувилбарыг сонгосон байх;

2.2.8.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон эрсдэлийн менежментийг тодорхойлон үнэлж, түүнийг бууруулах, зохицуулах төлөвлөгөөтэй байх;

2.2.9.олон улс, бүс нутаг, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, бусад дэд бүтцийн төлөвлөлттэй нийцсэн байх;

2.2.10.судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан хэлбэрээр боловсруулсан байх;

2.2.11.төмөр замын ашиглалтын үеийн аюулгүй байдал,

сэргээн босголтын зохион байгуулалтын шийдлийг тусгах, даатгалын системээр зохицуулах боломжийг судалсан байх.

2.3.Захиалагчийн хүсэлтээр техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (цаашид “ТЭЗУС” гэх) эсхүл техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх) боловсруулж болно.

2.4.ТЭЗУС-г боловсруулахдаа төслийн судалгааны хэсэг, чиглэл, чиг, түүний хувилбар, байршил, урьдчилсан шатны инженерийн зураг төсөл, нийгэм, эдийн засаг болон санхүүгийн үр ашиг, байгаль орчны судалгааг хамааруулсан байна.

2.5.ТЭЗҮ-ийг боловсруулахдаа урьдчилсан судалгаанд тулгуурлан инженерийн нарийвчилсан шийдэл, инженер хайгуулын судалгаа, норм, стандарт, урьдчилсан шатны инженерийн зураг төсөл, технологийн шийдэл, төсвийн тооцоо, санхүүжилтийн төлөвлөлтийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх эцсийн дүгнэлтийг илэрхийлж, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийсэн байна.

2.6.ТЭЗҮ-ийг боловсруулахдаа төслийн онцлог, цар хүрээ, техникийн шийдэл, хэрэгжилтийн үе шат зэргийг харгалзан дараах иж бүрдэл хэсгүүдийг тусгана. Захиалагч нь ажлын даалгаварт тайлангийн бүтэц, агуулгыг нарийвчлан тодорхойлсон байна. Үүнд:

2.6.1.төслийн танилцуулга: төслийн товч хураангуй, хэрэгжүүлэх зорилго, зорилт, төслийг хэрэгжүүлэх үндэслэл, хамрах хүрээ, хэрэгжилтийн үе шат, хэрэгжүүлэх хугацаа, нийт хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэрийн ерөнхий мэдээллийг тусгасан байна.

2.6.2.зах зээлийн судалгаа, шинжилгээ: төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн эрэлт хэрэгцээ, хэрэглэгчдийн сегментчилэл, өрсөлдөх орчин, макро болон микро орчны шинжилгээ, өнөөгийн зах зээлийн нөхцөл байдал, ирээдүйн эрэлт, нийлүүлэлтийн төлөв, зах зээлийн өсөлтийн хандлагын таамаглалыг багтаасан байна.

2.6.3.техникийн шийдэл, байршил зүйн шинжилгээ: төслийн байршил болон суурь бүтцийн чиг сонголт, суурь бүтцийн зохион байгуулалт, үндсэн болон дагалдах техникийн үзүүлэлтүүд, тээвэр зохион байгуулалт, тээвэрлэлт болон зүтгүүрийн татах хүчин чадлын тооцоо, ашиглагдах тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүн, технологийн шийдэл, хүний нөөцийн хэрэгцээ, инженерийн байгууламжийн төлөвлөлт, инженер-геологийн суурь судалгаа, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, дүн шинжилгээг тусгасан байна.

2.6.4.Бодлого, хууль, эрх зүйн шинжилгээ: Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, тухайн бүс нутаг, орон нутгийн эдийн засаг, аж үйлдвэржилтийн хөгжлийн бодлого, төрөөс төмөр

замын тээврийн талаар баримтлах бодлого, бусад салбарын бодлогын уялдаа, хэрэгжилтийн үр дагаврын шинжилгээ, төслийг хэрэгжүүлэхэд хамаарах хууль, эрх зүйн зохицуулалт, шаардлагатай зөвшөөрөл, лицензийн нөхцлийг тусгасан байна.

2.6.5.хүрээлэн буй орчин ба эрсдэлийн шинжилгээ: төслийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, нийгэм, эдийн засгийн үр дагаврын үнэлгээ, ногоон байгууламж, хог хаягдлын менежмент, байгальд ээлтэй, ногоон технологийн шийдэл, түүнчлэн зах зээлийн, технологийн, хууль эрх зүйн, хүний нөөцийн болон гадаад, дотоодын өрсөлдөөний эрсдэлийн тодорхойлолт, үнэлгээ, бууруулах арга хэмжээний шинжилгээг багтаасан байна.

2.6.6.урьдчилсан шатны инженерийн зураг төсөл: үндсэн байгууламж ба суурь бүтцийн зураг, тоо хэмжээний болон өртгийн тооцоо, техник, технологийн шаардлагыг тодорхойлсон зураг төслийн баримт бичгийг боловсруулсан байна.

2.6.7.санхүү, эдийн засгийн тооцоо: төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжилтийн бүтэц, орлого, зардлын тооцоо, ашигт ажиллагаа, хөрөнгө оруулалтын өгөөж, эргэн төлөгдөх хугацаа, санхүү, эдийн засгийн эрсдэлийн үнэлгээ, мэдрэмжийн шинжилгээг тусгасан байна.

2.7.ТЭЗУС болон ТЭЗҮ-ийг салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлэх ба Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Шинжлэх ухаан, технологийн зөвлөл эцсийн шийдвэр гаргана.

ГУРАВ. ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

3.1.Төмөр замын зураг төслийн баримт бичиг боловсруулахдаа хоёр үе шаттай байж болно.

3.1.1.нэг үе шаттай төмөр замын зураг төслийг “инженерийн нарийвчилсан зураг төсөл”, хоёр үе шаттай төмөр замын зураг төслийг “урьдчилсан шатны инженерийн зураг төсөл ба инженерийн нарийвчилсан зураг төсөл” гэж ангилна.

3.1.2.Захиалагч нь зураг төсөл боловсруулах үе шатыг ажлын даалгавар эсхүл зураг төслийн байгууллагатай байгуулах гэрээнд тодорхой тусгаж өгнө.

3.2.Шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагч, Захиалагч зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын төсөлд төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжүүдээс санал авч болно.

3.3.Эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцөл, дүгнэлтийг үндэслэн зураг төсөл боловсруулна.

3.4.Нийтийн болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын суурь бүтцийн ТЭЗУС, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг төрийн захиргааны байгууллага, салбар замын зураг төслийн ажлын даалгаврыг Захиалагч батална.

3.5.Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт зураг, төсөв, өртгийн нэгдсэн тооцоонд заавал магадлал хийх талаар тодорхой тусгасан байна.

3.6.Захиалагч нь төмөр замын зураг төслийн санхүүжилт болон байгаль орчны асуудал, газар олголт, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой зөвшөөрөл, техникийн нөхцөл, дүгнэлт гэх мэт бусад асуудлыг хариуцаж гүйцэтгэнэ.

3.7.Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөх ажлын техникийн шаардлага нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн байна. Тухайн хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, газар нутгийн нөхцөл байдал, онцлогт тохируулан техникийн шаардлагыг төсөл болгонд тусгайлан боловсруулна.

3.8.Төмөр замын зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл нь төслийн танилцуулга, батлагдсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, төсөл хэрэгжүүлэх үндэслэл, эрх зүйн баримт бичгүүд, төслийн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөл, төмөр замын суурь бүтцийн чигийн сонголт, газар олголтын шийдвэр, төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийн тооцоо, тээх, нэвтрүүлэх чадварын тооцоо, зүтгүүрийн татах тооцоо, зурмаг, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалт, дохиолол холбоо, ус хангамж, цахилгаан, инженерийн шугам сүлжээ, бусад дэд бүтэц, техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулахтай холбоотой хийсэн уулзалт, хурлын тэмдэглэл, албан бичиг, акт, дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг багтаасан байна.

3.9.Инженерийн нарийвчилсан зураг төслийн тайланд тавигдах шаардлага, агуулгыг төслийн онцлогоос хамааруулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тусгасан байна.

3.10.Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөх болон салбар замын зураг төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртгийг тооцохдоо төмөр замын барилга байгууламжийн ажлын төсвийн суурь нормын дагуу гүйцэтгэх ба төсөвт өртгийн нэгдсэн тооцоог хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох техникийн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, аргачлалын дагуу тооцож гүйцэтгэнэ.

3.11.Төмөр замын зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл нь төмөр замын тээврийн тухай хууль болон холбогдох норм, дүрэм, стандартад заасны дагуу боловсруулагдсан байна.

3.12. Зураг төслийн байгууллага нь мэргэжлийн тодорхой шийдэл гаргах шаардлагатай тохиолдолд Захиалагчаас зөвлөмж авч болно.

3.13. Зураг төслийн байгууллага нь энэхүү журмын 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.12-д заасан баримт бичиг, магадлалын ерөнхий дүгнэлт болон холбогдох бусад баримт бичгийг Захиалагчид хүлээлгэн өгч акт үйлдэнэ.

3.14. Эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцөлийн дүгнэлтэд төмөр замын зураг төслийг зөвшилцөх байгууллагыг тодорхой зааж өгнө.

3.15. Төмөр замын зураг төслийг боловсруулахдаа дараах байгууллагатай зөвшилцсөн байна.

3.15.1. Захиалагч;

3.15.2. газар олголт, төв суурин газрын хот байгуулалт, ерөнхий төлөвлөлтийн асуудал хариуцсан байгууллага;

3.15.3. дэд бүтэц болон түүний шугам сүлжээний ашиглалт хариуцсан байгууллага (шаардлагатай тохиолдолд);

3.15.4. холбогдох бусад байгууллага;

3.16. Төмөр замын зураг төслийн нүүр хуудсанд Захиалагч болон зураг төслийн байгууллага нь тамга, тэмдэг дарж, гарын үсгээр баталгаажуулна.

3.17. Төмөр замын зураг төслийн баримт бичгийн хуудас бүрийг энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан “зураг, төслийн булангийн хүснэгтийн загвар”-ын дагуу зурж, баталгаажуулсан байна.

3.18. Баталгаажсан төмөр замын суурь бүтцийн зураг төсөлд өөрчлөлт, шинэчлэлт оруулах тохиолдолд зөвхөн зураг төсөл боловсруулсан байгууллагаас албан бичгээр авсан тайлбар, дахин баталгаажуулалт хийгдсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ

4.1. “Инженерийн нарийвчилсан зураг төсөл”-д ажлын 21 хоногт багтаан магадлал хийнэ.

4.2. Зураг төслийг ажлын даалгаврын дагуу болон иж бүрдэл нь бүрэн эсэхийг Захиалагч хянасан байна.

4.3. Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл нь ажлын даалгавраас хамаарч дараах баримт бичгийн бүрдэлтэй байна.

4.3.1. төмөр замын суурь бүтцийн чиг тогтоосон шийдвэр;

4.3.2. техникийн нөхцөл;

4.3.3. зураг төсөл боловсруулах ажлын даалгавар;

4.3.4. ТЭЗҮ-ийн тайлан (урьдчилсан шатны инженерийн зураг төсөл);

4.3.5. инженер-геологийн тайлан, дүгнэлт;

4.3.6. ус зүйн судалгааны тайлан;

- 4.3.7.инженер-геодезийн хэмжилтийн тайлан;
- 4.3.8.археологи, палеонтологи, угсаатны зүйн авран хамгаалах тандалт судалгаа;
- 4.3.9.байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, дүгнэлт;
- 4.3.10. инженерийн тооцоо (Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын судалгаа, татах тооцоо, тээх нэвтрүүлэх чадварын тооцоо, технологийн схем, зурмаг, богиносголтой зам төмрийн тооцоо г.м);
- 4.3.11.материалын нөөц олборлох эх үүсвэрийн судалгааны тайлан;
- 4.3.12.төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, ажлын тоо хэмжээ;
- 4.3.13.дохиолол, холбооны зураг төсөл;
- 4.3.14.цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төсөл;
- 4.3.15.төмөр замын дэд бүтцийн барилга, байгууламжийн иж бүрэн зураг төсөл;
- 4.3.16.төмөр замын тоног төхөөрөмжийн зураг төсөл, тайлан (техникийн тодорхойлолт);
- 4.3.17.инженерийн зураг төслийн тайлан;
- 4.3.18.төсөвт өртгийн нэгдсэн тооцоо;
- 4.3.19.техникийн шаардлага;
- 4.3.20.бусад холбогдох баримт бичиг байна.
- 4.4.Салбар замын зураг төсөл дараах бүрдэлтэй байна.
 - 4.4.1.Салбар замын зураг төсөлд энэхүү журмын 4.3.2, 4.3.3, 4.3.5, 4.3.6, 4.3.7, 4.3.8, 4.3.12, 4.3.15, 4.3.17, 4.3.18, 4.3.19, 4.3.20 дахь заалтуудыг хамааруулна.
 - 4.4.2.энэхүү журмын 4.3.5, 4.3.8 дахь заалтад сүүлийн 5 жилд хийгдсэн судалгааны тайланг үндэслэж болно /шаардлагатай тохиолдолд/;
 - 4.4.3.байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан;
 - 4.4.4.дохиолол, холбооны зураг /шаардлагатай тохиолдолд/;
 - 4.4.5.төмөр замын тоног төхөөрөмж бүхий байгууламжтай бол түүний зураг, тайлан /техникийн тодорхойлолт/;
- 4.5.Зураг төслийг дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилж шифрлэсэн байна.
 - 4.5.1.төмөр замын дээд, доод бүтцийн зураг төсөл;
 - зам барилга, өргөтгөл, шинэчлэл ажил – Шифр:ТЗ-11-Зургийн дугаар.
 - төсөв, үнэ бүрдлийн тооцоо – Шифр:ТЗ-12-Зургийн дугаар.
 - 4.5.2.гүүр, хоолойн зураг төсөл;
 - барилга, өргөтгөл, шинэчлэл ажил – Шифр:ТЗ-21-Зургийн дугаар.

- төсөв, үнэ бүрдлийн тооцоо – Шифр:ТЗ-22-Зургийн дугаар.
4.5.3.дохиолол, холбооны зураг төсөл;
- барилга, өргөтгөл, шинэчлэл ажил – Шифр:ТЗ-31-Зургийн дугаар.

- төсөв, үнэ бүрдлийн тооцоо – Шифр:ТЗ-32-Зургийн дугаар.
4.5.4.бусад техник технологи бүхий инженерийн байгууламжийн зураг төсөл;
- барилга, өргөтгөл, шинэчлэл ажил – Шифр:ТЗ-41-Зургийн дугаар.

- төсөв, үнэ бүрдлийн тооцоо – Шифр:ТЗ-42-Зургийн дугаар.
4.5.5.салбар зам;
- зам барилга, өргөтгөл, шинэчлэл ажил – Шифр:ТЗ-51-Зургийн дугаар.

- төсөв, үнэ бүрдлийн тооцоо – Шифр:ТЗ-52-Зургийн дугаар.

Тайлбар: зургийн дугаар нь Захиалагч тухайн төслийн хүрээнд хийж буй төслийн нэр, зургийн төрөл тус бүрт оноосон дугаарлалт байна.

4.6.Төрийн захиргааны байгууллага нь зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.

4.6.1.төмөр замын дээд, доод бүтэц, гүүр, хоолой, дохиолол холбоо, бусад техник технологи бүхий инженерийн байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд магадлал хийж, Магадлалын ерөнхий дүгнэлт гаргана;

4.6.2.салбар замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, төсөвт Захиалагчийн хүсэлтээр магадлал хийлгэж болно.

4.6.3.эрчим хүч, усан хангамж, техник технологи бүхий инженерийн байгууламжийн зураг төсөлд магадлал хийх тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас эрх авсан шинжээчийг гэрээгээр татан оролцуулж болно;

4.6.4.зураг төслийн төсөвт өртөгтэй магадлал хийхтэй холбогдох мэргэжлийн байгууллагуудаас тэргүүлэх төсөвчин эрхийг авсан төсөвчинг гэрээгээр татан оролцуулна;

4.6.5.магадлал хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж, энэ журмын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан зураг төсөлд шинжээч томилон, Захиалагч, зураг төслийн байгууллагатай магадлал хийх гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина;

4.6.6.төмөр замын зураг төсөлд магадлал хийх шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гурав /3/ хүртэлх жилийн хугацаатай шинжээчийн эрх олгох, гэрээ байгуулах, дүгнэх, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа, зөрчил гаргасан шинжээчийн эрхийг цуцлах, хариуцлага тооцох арга

хэмжээ авна;

4.6.7. магадлал хийх эрх олгосон иргэн эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгааны улмаас магадлал хийх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр магадлал хийхээс татгалзсан, Захиалагч хүсэлт гаргасан бол шинжээчийн сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулж болно;

4.6.8. төмөр замын зураг төслийн чанарыг дээшлүүлэх болон магадлал хийх үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж гарган хэрэгжүүлнэ;

4.6.9. төмөр замын зураг төслийн баримт бичигт магадлал хийхтэй холбоотой маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд мэргэжлийн комисс томилон, гаргасан зөвлөмжийг үндэслэн шийдвэр гаргана;

4.6.10. магадлалын ерөнхий дүгнэлт болон шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийн маягт, зураг төсөл зэргийг баталгаажуулах тэмдгийн загварыг батлан, шинжээчид хувийн дугаар олгоно.

4.7. Магадлал хийгдсэн төсөвт төмөр замын барилга байгууламжийн ажлын төсвийн суурь нормд өөрчлөлт орсон тохиолдолд дахин магадлал хийлгэж болно.

4.8. Хийц, технологийн онцлогоос хамаарсан онцгой төвөгшилтэй зураг төсөлд шинжээчийн багийг томилон ажиллуулж, төмөр замын зураг төслийн ажлын үе шат бүрд хяналт тавих замаар хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд энэхүү журмын 4.1 дэх заалт хамаарахгүй.

4.9. Магадлагдсан зураг төсөлд Захиалагчийн шийдвэрээр өөрчлөлт оруулах бол зөвхөн өөрчлөлт орсон хэсгийг магадлал хийх бөгөөд дараах баримт бичгийг үндэслэнэ.

4.9.1. зураг төсөлд өөрчлөлт оруулах үндэслэл, холбогдох баримт бичиг, шийдвэр;

4.9.2. төмөр замын барилга, байгууламжийн зураг, төсөлд өөрчлөлт оруулах гэрээ.

4.10. Зураг төсөлд магадлал хийх зардлын хэмжээ нь тухайн зураг төсөл боловсруулах ажлын Захиалагч, зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний үнийн дүнгийн 8 хувиар тооцох бөгөөд үүнээс магадлал хийж, Магадлалын ерөнхий дүгнэлт гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулах болон бусад үйл ажиллагаа (мэдээллийн сан, бүртгэл хөтлөлт, программ хангамж)-нд зориулан 30 хувийг, магадлал хийх шинжээч болон төсөвчингийн цалинд зориулж 70 хувийг нь тус тус хуваарилж олгоно. Төмөр замын зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрд магадлал хийх шинжээч болон төсөвчний цалингаас ногдох зардлын 80 хувийг инженерийн нарийвчилсан зураг төслийн магадлал хийх, 20 хувийг төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд

магадлал хийхэд тус тус хуваарилна.

4.11.Магадлал хийх ажлын зардлыг төлсөн баримтыг үндэслэн “Магадлалын ерөнхий дүгнэлт”-ийг зураг төслийн байгууллагад хүлээлгэн өгнө.

4.12.Зураг төсөлд магадлал хийх шинжээч болон төсөвчин нь дараах шаардлагыг хангасан байна.

4.12.1.шинжээч нь тухайн мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, тухайн чиглэлээр зөвлөх инженер зэрэгтэй байх;

4.12.2.төсөвчин нь 10-аас доошгүй жил төсөвчнөөр ажилласан, тэргүүлэх төсөвчин зэрэгтэй байх;

4.12.3.шинжээч болон төсөвчин нь ёс зүйн доголдолгүй, аливаа ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн зураг төслийг боловсруулсан байгууллагад шууд болон шууд бусаар харьяалагддаггүй, хувьцаа эзэмшдэггүй байх;

4.12.4.шинжээч нь төрийн захиргааны байгууллагад нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг хүргүүлсэн байх.

4.13.Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан материалыг тогтоосон хугацаанд хүлээн авч, бүртгэнэ. Үүнд:

4.13.1.хүсэлт;

4.13.2.ажил байдлын тодорхойлолт;

4.13.3.мэдлэг, чадвар, туршлагыг тодорхойлсон товч намтар;

4.13.4.дээд боловсролын диплом болон Зөвлөх инженерийн гэрчилгээний хуулбар.

4.14.Шинжээч нь зураг төсөлд магадлал хийсэн бүрдэл хэсэг тус бүрд мэргэжлийн дүгнэлтийг хуанлийн 14 хоногт багтаан гаргаж, холбогдох хуудаснуудад хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулах ба дүгнэлтээ төрийн захиргааны байгууллагад болон зураг төслийн байгууллагад цахимаар, мөн хэвлэмэл хэлбэрээр тухай бүр хүргүүлж ажиллана.

4.15.Тухайн төсөл арга хэмжээний цар хүрээ, хүчин чадал, ажлын тоо хэмжээнээс хамааруулан төрийн захиргааны байгууллага нь Хүснэгт 4-1-д заасны дагуу тохирох тооны шинжээч эсвэл шинжээчийн багийг томилно.

Хүснэгт 4-1.

| № | Төмөр замын барилга, байгууламжийн зураг төсөл | Хүчин чадал | Томилгооны хэлбэр | Тайлбар |
|--------|--|--|-------------------|---|
| 4.15.1 | Төмөр замын дээд, доод бүтэц | 50 км хүртэл | Шинжээч | Тухайн төслийн ач холбогдол, онцгой төвөгшил зэргээс хамаарч шинжээчийн баг томилж болно. |
| | | 50 км-ээс дээш | Шинжээчийн баг | |
| 4.15.2 | Гүүр, хоолой | 0-399 у/м | Шинжээч | |
| | | 400 у/м-ээс дээш | Шинжээчийн баг | |
| 4.15.3 | Дохиолол холбоо | Төвлөрүүлэгдсэн 9 сум хүртэл | Шинжээч | |
| | | Төвлөрүүлэгдсэн 10 сумаас дээш | Шинжээчийн баг | |
| 4.15.4 | Онцгой төвөгшилтэй инженерийн байгууламж | Туннель, эстакад, галерей, штолен, тулц хана, уулзваргүй зам, гулгамтгай, суулттай, нуралт ихтэй бүсийн замын байгууламж, газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд тусгай тооцоололтой баригдсан байгууламж, төмөр замын томоохон зангилаа, огтлолцол, шилжүүлэлтийн цогцолбор, Голын урсац сэлгэлт, усны том байгууламжтай хэсэг, г.м. | Шинжээчийн баг | Төмөр замын онцгой төвөгшилтэй инженерийн байгууламжийн онцлогоос хамаарч холбогдох нарийн мэргэжлийн шинжээчийг томилно. |

4.16.Зураг төсөлд засвар оруулах шаардлагатай тохиолдолд шинжээчийн гаргасан мэргэжлийн дүгнэлтийн дагуу зураг төслийн байгууллага зохих засварыг гүйцэтгэх бөгөөд тайлбарыг гаргаж, шинжээчид дахин хянуулснаар шинжээчийн хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө;

4.17.Шинжээч нь зураг төсөлд магадлал хийхдээ дараах шаардлагыг хангасан эсэхийг хянаж, мэргэжлийн дүгнэлт гарган холбогдох засвар, өөрчлөлтийг тусгуулна.

4.17.1.төмөр замын суурь бүтцийн чиг, байршил, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;

4.17.2.инженерийн шийдэл, хийц бүтээц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;

4.17.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;

4.17.4.галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдлын шаардлагыг хангуулсан эсэх;

4.17.5.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан эсэх;

4.17.6.инженер геологийн нөхцөл, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл;

4.17.7.эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;

4.17.8.шинжээчийн мэргэжлийн дүгнэлтэд хууль тогтоомж, стандарт, нормын шаардлагыг үндэслэн технологийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, зураг төслийг өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгах бөгөөд магадлал хийгдсэн зургаар барилгын ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлсон байна.

4.18.Тэргүүлэх төсөвчин нь төсөвт өртгийн нэгдсэн тооцооны дүнг баталгаажуулна.

4.19.Магадлалын ерөнхий дүгнэлт нь төмөр замын суурь бүтэц болон салбар замын төлөвлөлт, инженерийн шийдлүүдэд өгөх мэргэжлийн үнэлгээ байх бөгөөд шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийн хамт хүчин төгөлдөр байна.

4.20.Шинжээч, төсөвчин баталгаажуулсан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэж төрийн захиргааны байгууллага нь ажлын 5 хоногт багтаан магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргана.

4.21.Магадлалын ерөнхий дүгнэлтийг 2 хувь үйлдэж төрийн захиргааны байгууллага гарын үсэг, тамгаар баталгаажуулна.

4.22. Зураг төслийг 2 хувь үйлдэж төрийн захиргааны байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга гарын үсэг зурж, магадлал хийгдсэн тэмдгээр баталгаажуулна. Шинжээч шаардлагатай хуудаснуудад гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулсан байна.

4.23.Төсөвт өртгийн нэгдсэн тооцоог 2 хувь үйлдэж төсөвчин бүх хуудсанд гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулна.

ТАВ. ЗУРАГ ТӨСЛИЙГ ХАДГАЛАХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ

5.1.Магадлалын ерөнхий дүгнэлтийг төрийн захиргааны байгууллагад 1 эх хувийг, зураг төслийн байгууллагад 1 эх хувийг тус тус хадгална.

5.2.Зураг төслийн байгууллага нь төмөр замын зураг төслийг магадлагдсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэснийг файл хэлбэрээр төрийн захиргааны байгууллагын цахим хаягаар ирүүлэх эсхүл цахим системд оруулна.

5.3.Төрийн захиргааны байгууллага нь магадлагдсан төмөр замын зураг төслийг холбогдох материалын хамт мэдээллийн нэгдсэн санд бүртгэл үүсгэнэ.

ЗУРГАА. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

6.1.Техник, технологийн хяналт тавих Зөвлөх нь төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг магадлагдсан инженерийн нарийвчилсан зураг, төсөв, норм, норматив, Захиалагч, гүйцэтгэгч хооронд байгуулсан гэрээний нөхцөл болон техникийн шаардлагын дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан, мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.2.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажилд техник, технологийн хяналт тавих Зөвлөх нь хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй байна.

6.3.Зөвлөх нь хяналт шалгалтаа дараах аргачлалаар хэрэгжүүлнэ:

6.3.1.барилгын үе шат бүрийн ажлыг газар дээр нь хянан шалгах;

6.3.2.ил, далд ажлын акт бичиг баримт, гүйцэтгэлийн зураг төсөлтэй тулгах;

6.3.3.төслийн явц, гүйцэтгэлийг долоо хоног бүр тайлагнаж, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээний саналыг Захиалагчид танилцуулах;

6.4.Хяналт шалгалтын явцад Зөвлөх нь дараах эрхтэй:

6.4.1.зураг төсөл, норм, стандарт зөрчсөн ажил гүйцэтгэлд баталгаажуулалт олгохоос татгалзах;

6.4.2.тохирлын үнэлгээ, материалын шинжилгээний дүгнэлт шаардах;

6.4.3.үндэслэл бүхий шаардлагыг биелүүлээгүй бол ажил зогсоох.

6.5.Зөвлөх нь дараах мэдээллийг тогтмол бүрдүүлж, хөтөлнө:

6.5.1.хяналт шалгалтын өдөр тутмын тэмдэглэл;

6.5.2.ажлын явцын фото зураг, байршил тогтоох систем ашигласан координат;

6.5.3.зөрчил, алдааны бүртгэл, шаардлагын акт;

6.5.4.тайлан, тэмдэглэл, зөвлөмжийн албан бичиг.

6.6.Хяналтын явцад илэрсэн зөрчил, алдааг дараах журмаар шийдвэрлэнэ:

6.6.1.албан шаардлага хүргүүлэх, засварлах үүрэг өгөх;

6.6.2.засвар хийсний дараа дахин хяналт хийж баталгаажуулах;

6.6.3.гүйцэтгэлд шаардлага хангаагүй ажилд төлбөрөөс татгалзах талаар Захиалагчид мэдэгдэх.

6.7.Хяналтын баримт бичиг, маягтыг батлагдсан загварын дагуу ашиглана.

6.7.1.Зөвлөх нь хяналт шалгалтын маягт, тайлангийн загварыг хууль, гэрээ, журмын дагуу ашиглана;

6.7.2.гадаадын зээл, тусламжийн төслүүд нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол мөн адил хэрэгжинэ.

6.8.Тусгай зөвшөөрөлд тусгайлан заагаагүй бол төмөр замын суурь бүтэц барих Зөвлөхийн бүрэлдэхүүн дараах мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

6.8.1.төмөр замын зам, барилгын инженер, бүтээцийн инженер;

6.8.2.цахилгаан хангамж, дохиолол, холбоо, автоматжуулалтын инженер (шаардлагатай төслүүдэд);

6.8.3.геотехникийн болон материал судлалын инженер;

6.8.4.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хяналтын инженер;

6.8.5.шаардлагатай тохиолдолд холбогдох нарийн мэргэжлийн бусад Зөвлөх.

6.9.Зөвлөхийн мэргэжилтнүүд нь дараах мэргэшлийн шаардлагыг хангасан байна.

6.9.1.бакалавр ба түүнээс дээш боловсролтой;

6.9.2.мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;

6.9.3.тухайн чиглэлийн төсөл гүйцэтгэсэн туршлагатай;

6.9.4.Зөвлөх нь дараах техникийн чадамж, нөөцтэй байна;

- шаардлагатай хэмжилтийн багаж, төхөөрөмж, программ хангамж;

- ажлын тайлан, бүртгэл, зураг хөтлөх техник хэрэгсэл (GPS, фото камер, дрон, принтер, цахим платформ г.м.);

- судалгаа шинжилгээ болон лабораторийн шинжилгээний хамтын ажиллагаатай, гэрээт байгууллагатай байх.

6.10.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийг гүйцэтгэлд нөлөөлөхүйц багийн гишүүнийг дараах тохиолдолд өөрчилж болно.

6.10.1.Захиалагчтай урьдчилан зөвшилцөн, тухайн албан тушаалд тохирох ижил түвшний мэргэжилтнийг орлох;

6.10.2.Зөвлөх багийн өөрчлөлтийн тухай мэдээллийг албан ёсоор баталгаажуулсан баримтаар нотлох;

6.11.Зөвлөх нь үйл ажиллагаагаа ил тод, баримтжуулсан байдлаар хэрэгжүүлэх бөгөөд дараах ёс зүйн зарчмыг мөрдөнө.

6.11.1.нууцлал, хөндлөнгийн байдлыг чанд сахих;

6.11.2.Захиалагчийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөхгүй байх;

6.11.3.илэрсэн зөрчлийг мэргэжлийн үнэн зөв үндэслэлээр тайлбарлаж, нотлох баримтаар баталгаажуулж ажиллах;

6.12.Захиалагч нь дараах эрх эдэлнэ.

6.12.1.төслийн явцад Зөвлөхөөс хяналт, үнэлгээ, тайлан, санал авах, шаардлагатай мэдээллийг шаардах;

6.12.2.хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар Зөвлөхийн хүргүүлсэн шаардлагыг үндэслэн гүйцэтгэгчид арга хэмжээ авах;

6.12.3.хуулийн хүрээнд гүйцэтгэлд санхүүжилт олгох, хойшлуулах, зогсоох шийдвэрийг гаргах;

6.12.4.Зөвлөх үйлчилгээний тайлан, санал, дүгнэлтийг үндэслэн өөрийн байгууллагын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;

6.12.5.Зөвлөхийн тайлагнал, хяналтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд хөндлөнгийн шинжээч томилуулж давхар хяналт тавих;

6.12.6.Зөвлөх үйлчилгээний багийн ажилтны мэргэжлийн чадамжид эргэлзээ гарсан тохиолдолд дахин үнэлгээ хийлгэхийг шаардах.

6.13.Захиалагч нь дараах үүрэг хүлээнэ.

6.13.1.зураг төсөл, техникийн шаардлага, магадлагдсан төсөв, гэрээний баримт бичиг болон бусад холбогдох материалыг Зөвлөхөд хугацаанд нь бүрэн, албан ёсоор шилжүүлэх;

6.13.2.хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, Зөвлөхийн багийг барилгын талбайд чөлөөтэй нэвтрэх, ажиллах боломжийг хангах;

6.13.3.Зөвлөхийн санал, дүгнэлтийг үндэслэн хүлээн авах, шаардлагатай арга хэмжээг гүйцэтгэгчид хэрэгжүүлэх;

6.13.4.Зөвлөх үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан нөхцөлөөр тооцон олгох;

6.13.5.гэрээнд заасан тохиолдолд Зөвлөх үйлчилгээний багийг солих, шинэчлэхтэй холбоотой зөвшилцөл хийх;

6.13.6.Зөвлөхийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй нэмэлт мэдээлэл, баримт бичгийг тухай бүрд нь гаргаж өгөх;

6.13.7.хяналтын дүн, тайланг хадгалах, төслийн архивд оруулах зохион байгуулалт хийх;

6.14.Зөвлөх нь дараах эрх эдэлнэ.

6.14.1.техник, технологийн хяналтын ажлыг бие даан, хараат бус байдлаар гүйцэтгэх;

6.14.2.барилгын ажлын гүйцэтгэлд зураг төсөл, норм, стандартын шаардлага, технологи зөрчигдсөн тохиолдолд баталгаажуулахаас татгалзах;

6.14.3.ил, далд ажлын акт, баримт бичигтэй тулган шалгах, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, баримт шаардах;

6.14.4.барилгын ажлын явц, материалын чанар, тоног төхөөрөмжийн тохирлын үнэлгээ, лабораторийн шинжилгээний дүгнэлт шаардах;

6.14.5.илэрсэн зөрчил, алдааг арилгуулах албан шаардлага хүргүүлэх, засвар дуусахаас нааш дараагийн үе шат руу шилжихийг хориглох санал гаргах;

6.14.6.үндэслэлтэй тохиолдолд ажлын тодорхой хэсгийг түр зогсоох талаар Захиалагчид бичгээр зөвлөмж өгөх;

6.14.7.хяналтын явцад илэрсэн зөрчлийг Захиалагч, холбогдох хяналтын байгууллагад мэдээлэх.

6.15.Зөвлөх нь дараах үүрэг хүлээнэ.

6.15.1.төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын бүх үе шатанд техник, технологийн хяналт тавих;

6.15.2.барилгын явц, ажлын чанар, норм стандартын хэрэгжилт, аюулгүй байдлыг газар дээр нь шалгах, бичгээр тэмдэглэх;

6.15.3.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зураг төслийн шийдлийн хараат бус хэрэгжилтийг хангах үүднээс зураг төсөл зохиогчийг тухайн зураг төсөлд барилгын ажил гүйцэтгэгчээр оролцуулахгүй байх;

6.15.4.хяналтын ажлын өдөр тутмын тэмдэглэл, зөрчил, акт, тайлан, зөвлөмж, фото зураг, газарзүйн байршлын координат тэмдэглэл зэрэг бүх баримт бичгийг бүрдүүлэн хөтлөх;

6.15.5.долоо хоног тутам ажлын явцын тайланг Захиалагчид танилцуулах;

6.15.6.илэрсэн зөрчил, алдааг цаг тухайд нь Захиалагчид мэдэгдэж, засвар арга хэмжээний санал хүргүүлэх;

6.15.7.гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг чанар, хугацаа, зураг төсөлд нийцсэн байдлаар үнэлж, баталгаажуулан санал дүгнэлт гаргах;

6.15.8.ажлын хүлээлцэх болон ашиглалтад хүлээн авах үе шатанд техникийн шаардлага хангасан эсэх талаар бүрэн дүгнэлт гаргаж, албан бичгээр баталгаажуулах;

6.15.9.Зөвлөх үйлчилгээний явцад гарсан мэдээлэл, баримтыг хуулийн заасан хүрээнд нууцлах, хөндлөнгийн байдлыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

6.16.Зөвлөх туслан гүйцэтгэгчтэй хамтран ажиллах тохиолдолд баримтлах нөхцөл, хариуцлага.

6.16.1.Зөвлөх нь хяналтын үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг гэрээний дагуу эрх бүхий туслан гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тухай Захиалагчтай урьдчилан зөвшилцөн, албан ёсоор баталгаажуулсан байна;

6.16.2.туслан гүйцэтгэгч нь тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, холбогдох зөвшөөрөл, чадамжтай байна;

6.16.3.туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг үндэслэн Зөвлөх нь эцсийн тайлан, дүгнэлтэд хариуцлага хүлээнэ;

6.16.4.туслан гүйцэтгэгчийн буруугаас үүдэн гарсан зөрчил, хохиролд Зөвлөх хуулийн болон гэрээний хариуцлага хүлээнэ.

6.17.Илэрсэн зөрчил арилгах хугацаа, давтан зөрчилд авах арга хэмжээ.

6.17.1.Зөвлөхөөс гаргасан албан шаардлага, зөрчлийн актын дагуу гүйцэтгэгч нь хуанлийн 7 хоногийн дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй. Тухайн зөрчлийн шинж чанар, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөнд үндэслэн зөрчил арилгах хугацаа сунгах асуудлыг Зөвлөх тодорхойлно;

6.17.2.засвар, залруулга хийсний дараа Зөвлөх дахин хяналт хийж, баталгаажуулсан дүгнэлт гаргана;

6.17.3.хэрэв нэг төрлийн зөрчил 2-оос дээш удаа давтагдсан, эсвэл зөрчлийг арилгахаас татгалзсан тохиолдолд дараах арга хэмжээ авна:

- Захиалагчид албан бичгээр хүргүүлж, хүлээлгэх санхүүгийн шийтгэлийн саналыг дэвшүүлэх;

- төслийн тухайн хэсгийн ажлыг түр зогсоох санал тавих;

- хяналтын тайланд “шаардлага хангаагүй” гэдэг дүгнэлт гаргаж, хүлээн авахгүй байх үндэслэл болгох;

- хуулийн байгууллагад мэдэгдэх буюу мэргэжлийн хяналтын байгууллагад санал хүргүүлэх.

6.18.Төмөр замын барилгын ажилд олон улсын Зөвлөх инженерүүдийн холбооны гэрээний жишиг нөхцөлийг баримтлан техник, технологийн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

6.19.Төмөр замын суурь бүтцийн барилга, өргөтгөл шинэчлэлийн ажлыг улсын комисс ашиглалтад хүлээн авснаар Зөвлөх үйлчилгээний ажлыг дуусгавар болгох ба холбогдох баримт бичгийг Захиалагчид бүрэн хүлээлгэн өгнө.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих Зөвлөх үйлчилгээний журмын нэгдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ ХЯНАХ МАЯГТ

1. Захиалагч байгууллага: *...
2. Объектын байршил: *...
3. Объектын нэр: *...
4. Хүчин чадал: *...
5. Хөрөнгө оруулалтын төрөл: **улсын төсвийн, хувийн, гадаад зээл тусламж /доогуур зурах/** *...
6. Ерөнхий гүйцэтгэгчийн **РД:** *...
7. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: *...
8. Ажилбарын төрөл: *...
9. Харилцах утас: *...

| № | утга | Баримт бичгийн товч утга | Хуудас /ш/ | Тайлбар | |
|----|---------------------|---|------------|---------|--|
| 1 | Үндсэн бичиг баримт | Газар эзэмших, ашиглах эрхийн эрх зүйн баримт бичгийн хуулбар | | *... | |
| 2 | | Төмөр замын суурь бүтцийн чиг тогтоосон шийдвэр | | | |
| 3 | | Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар | | *... | |
| 4 | | Зураг төсөл боловсруулах гэрээ | | *... | |
| 5 | | ТЭЗҮ-ийн тайлан (урьдчилсан шатны инженерийн зураг төсөл) | | *... | |
| 6 | | Инженер-геологийн тайлан, дүгнэлт | | *... | |
| 7 | | Ус зүйн судалгааны тайлан | | *... | |
| 8 | | Инженер-геодезийн хэмжилтийн тайлан | | *... | |
| 9 | | Археологи, палеонтологи, угсаатны зүйн авран хамгаалах тандалт судалгаа | | *... | |
| 10 | | Байгаль орчны төлөв байдлын тайлан, дүгнэлт; | | *... | |

| | | | | | | |
|----|--|--|----------------------------|--------------------------------|------------------------------|---------------|
| 11 | Инженерийн тооцоо | Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын судалгаа | | *... | | |
| 12 | | Татах болон тээх нэвтрүүлэх чадварын тооцоо | | *... | | |
| 13 | | Технологийн схем | | *... | | |
| 14 | | Зурмаг | | *... | | |
| 15 | | Богиносголтой зам төмрийн тооцоо | | *... | | |
| 16 | | Бусад тооцоо | | *... | | |
| 17 | | Материалын нөөц олборлох эх үүсвэрийн судалгааны тайлан | | *... | | |
| 18 | | Төмөр замын инженерийн нарийвчилсан зураг | | *... | | |
| 19 | Дохиолол, холбооны зураг | *... | | | | |
| 20 | Цахилгаан, гэрэлтүүлгийн зураг | *... | | | | |
| 21 | Төмөр замын дэд бүтцийн барилга, байгууламжийн иж бүрэн зураг; | | | | | |
| 23 | Төмөр замын тоног төхөөрөмжийн зураг, тайлан (техникийн тодорхойлолт); | *... | | | | |
| 24 | Инженерийн зураг төслийн тайлан; | *... | | | | |
| 25 | Ажлын тоо хэмжээ; | *... | | | | |
| 26 | Төсөвт өртгийн нэгдсэн тооцоо; | *... | | | | |
| 27 | Техникийн шаардлага | *... | | | | |
| 28 | Бусад холбогдох баримт бичиг | | | | | |
| | | Үндсэн техникийн нөхцлүүд | Олгосон байгууллага | Олгосон огноо / дугаар/ | Хүчинтэй байх хугацаа | Тайбар |
| 29 | Зам барих техникийн нөхцөлийн дүгнэлт | *... | *... | *... | | |
| 30 | Төмөр замын дохиолол, холбоо | *... | *... | *... | | |
| - | Бусад | *... | *... | *... | | |
| | | Туслах дэд бүтцийн техникийн нөхцөл (шаардлагатай тохиолдолд) | Олгосон байгууллага | Олгосон огноо / дугаар/ | Хүчинтэй байх хугацаа | Тайбар |
| 31 | Дулаан хангамж | *... | *... | *... | | |
| 32 | Ус хангамж, ариутгах татуурга | *... | *... | *... | | |
| 33 | Усны барилга байгууламж | *... | *... | *... | | |

| | | | | | |
|----|--------------------------|------|------|------|--|
| 34 | Цахилгаан хангамж | *... | *... | *... | |
| 35 | Мэдээлэл, холбоо, сүлжээ | | | | |

| | Зураг төслийн иж бүрдэл | Зургийн марк, товчлол | Хуудасны формат | Хуудасны тоо | Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж /туслан гүйцэтгэгч/ | Зураг төсөл гүйцэтгэсэн инженер | 2 дахь инженер шалгаж гарын үсэг зурсан эсэх | |
|----|-------------------------|--|-----------------|--------------|---|---------------------------------|--|--|
| 36 | Зураг төслийн иж бүрдэл | Нүүр хуудас | НХ | | | | | |
| 37 | | Дэвсгэр ба дагуу огтлолын зураг | ДДОз | | | | | |
| 38 | | Замын тахирын үзүүлэлт | ТҮ | | | | | |
| 39 | | Замын тэнхлэгийн координатын хүснэгт /улаан шугам/ | УШх | | | | | |
| 40 | | Зам, сумын товьёг | ЗСТ | | | | | |
| 41 | | Хөндлөн огтлолын зураг | ХОз | | | | | |
| 42 | | Нэг маягийн зураг | НМз | | | | | |
| 43 | | Суман шилжүүлгийн зураг, солбицлын хүснэгт | СШз Сх | | | | | |
| 44 | | Замын дээд бүтцийн зураг | ЗДБз | | | | | |
| 45 | | Богиносголтой зам төмрийн тооцоо | ЗТТ | | | | | |
| 46 | | Зам барих зураг | ЗБз | | | | | |
| 47 | | Огтлолцлын зураг | Оз | | | | | |
| 48 | | Төмөр замын холбогдох тоног төхөөрөмжийн зураг | ТТз | | | | | |

| | | | | | | | | | |
|----|-------------------------|---|------|--|--|--|--|--|--|
| 49 | | Ус зайлуулах шуудууны зураг | Уз | | | | | | |
| 50 | | Шороон болон чулуун ордын судалгаа, байршил | ШЧОс | | | | | | |
| 51 | | Хиймэл байгууламж | ХБ | | | | | | |
| 52 | | Тайлбар бичиг | Тб | | | | | | |
| 53 | | Техникийн шаардлага | ТШ | | | | | | |
| 54 | | Ажлын тоо хэмжээ | АТХ | | | | | | |
| 55 | | Төсвийн тооцоо | ТТ | | | | | | |
| 56 | | Бусад | - | | | | | | |
| 57 | Инженерийн шугам сүлжээ | Дохиолол, холбоо | ДТХ | | | | | | |
| 58 | | Бусад | - | | | | | | |
| 59 | | Төсөв /улсын төсвийн хөрөнгө оруулалттай/ мян.төг | | | | | | | |

ЗУРАГ ТӨСӨЛ ЗӨВШИЛЦСӨН БАЙДАЛ:

| Зөвшилцсөн байгууллагууд | № | Холбогдох газрууд | Тайлбар |
|--------------------------|---|---|---------|
| | 1 | Захиалагч | * |
| | 2 | газар олголт, төв суурин газрын хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний асуудал хариуцсан байгууллага; | * |
| | 3 | Дэд бүтэц болон түүний шугам сүлжээний ашиглалт, төлөвлөлт хариуцсан байгууллага (шаардлагатай тохиолдолд); | * |
| | 4 | Холбогдох бусад байгууллага; | * |

* - Хүсэлт гаргасан байгууллага бөглөнө.

Хүлээн авсан:

Хүлээлгэн өгсөн:

..... оны сарын

Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих Зөвлөх үйлчилгээний журмын хоёрдугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТИЙН МАЯГТ, МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН МАЯГТ, ТЭДГЭЭРИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ТЭМДГИЙН ЗАГВАР

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТИЙН МАЯГТ

1.1.Зураг төсөлд магадлал хийсэн шинжээч мэргэжлийн дүгнэлтээ дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

.....
.....

... оны сарын өдөр

| № | Утга | Тайлбар |
|-----|---|---------|
| 1 | Объектын нэр | |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | |
| 3 | Зураг төслийн байгууллага | |
| 4 | Дүгнэлтийн товч утга: | |
| 4.1 | төмөр замын суурь бүтцийн чиг, байршил, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | |
| 4.2 | инженерийн шийдэл, хийц бүтээц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | |
| 4.3 | хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх; | |
| 4.4 | галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдлын шаардлагыг хангуулсан эсэх; | |
| 4.5 | хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан эсэх; | |
| 4.6 | инженер геологийн нөхцөл, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл; | |
| 4.7 | эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | |

| | | |
|---|--|--|
| 4.8 | шинжээчийн мэргэжлийн дүгнэлтэд хууль тогтоомж, стандарт, нормын шаардлагыг үндэслэн технологийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, зураг төслийг өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгах бөгөөд магадлал хийгдсэн зургаар барилгын ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлсон байна. | |
| Дүгнэлт бичсэн: | | |
| Шинжээчийн № овог, нэр /гарын үсэг/ | | |
| 20. оны ... сарын -ны өдөр | | |

1.2.Төмөр замын зураг төслийн бүрдэл болох Төсвийн тооцоонд магадлал хийсэн шинжээч дүгнэлтээ дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /Төсвийн тооцоо/

| № | Утга | Тайлбар |
|---|---|---------|
| 1 | Объектын байршил, хүчин чадал | |
| 2 | Объектын нэр, шифр | |
| 3 | Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага | |
| 4 | Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер | |
| 5 | Төмөр замын суурь бүтцийн барилга, өргөтгөл, шинэчлэл ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал | |
| 6 | Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ | |
| 7 | Төсвийн тооцооны арга. аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал | |
| 8 | Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай завсар, өөрчлөлт | |
| | Дүгнэлтийн товч утга | |
| 1 | Төвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу, оновчтой зохиогдсон эсэх | |
| Дүгнэлт бичсэн: | | |
| Шинжээчийн № овог, нэр /гарын үсэг/ | | |
| . оны ... сарын -ны өдөр | | |

Шинжээч дүгнэлтийг компьютероор 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

ХОЁР. МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН МАЯГТ

2.1.Төмөр замын барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлтийг дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗАР ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот
Утас: (51) 261196

| | | | |
|---|---|---------------|--------------------------|
| Объектын нэр: | | | |
| Объектын байршил: | | | |
| Хүчин чадал: | | | |
| Захиалагч: | | | |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | | | |
| Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр: | | | |
| Регистрийн дугаар: | | | |
| Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: | | | |
| <u>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</u> | | | |
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | | | |
| Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | | | |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | | | |
| <u>Техникийн нөхцөл:</u> | | | |
| Техникийн нөхцөл | Олгосон байгууллага | Дугаар, огноо | Хүчинтэй хугацаа |
| | | | |
| <u>Зөвшөөрсөн байгууллагууд:</u> | | | |
| | | | |
| <u>Зураг төслийн бүрэлдэхүүн</u> | Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр: | | Шалгасан шинжээчийн нэр: |
| | | | |
| <u>Ерөнхий дүгнэлт:</u> | | | |
| Төмөр замын суурь бүтэц, салбар замын чигийн сонголт болон техник, эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт: | | | |

| | |
|---|--|
| Боловсруулсан төмөр замын зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт: | |
| Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт: | |
| Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт: | |

..... нутаг дэвсгэрт баригдах “.....”-ны барилгын ажлын зураг төсөлд “Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих Зөвлөх үйлчилгээний журам”-ын дагуу шинжээчид магадлал хийсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь шинжээчийн хавсралт ...хуудас дүгнэлтийн хамт хүчинтэй болно.

/Хавсралт: ... хуудастай/

НЭГЖИЙН ДАРГА /...../

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /...../

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /...../

**ГУРАВ. ШИНЖЭЭЧИЙН МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТ, МАГАДЛАЛЫН
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ТЭМДГИЙН ЗАГВАР**

3.1. Шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг баталгаажуулах тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 55x40 мм-ийн голчтой, зуйван дугуй хэлбэртэй, гадна давхар хүрээний дотор талд дараах бичвэртэй байна.



3.2. Магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулах тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 100x65 мм-ийн дөрвөлжин хэлбэртэй, гаднаа давхар хүрээтэй, хүрээний дотор талд дараах бичвэртэй байна.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАЛАНЗАДГАД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 09/05

Даланзадгад
сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Даланзадгад сумын малчин, мал бүхий этгээдийн малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоосон тогтоолыг хэрэгжүүлж, татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Дэнээдорж)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 3/5 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.НАЦАГДОРЖ

*Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн
09/05 тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

(Төгрөгөөр)

| № | Малын төрөл | Татварын хэмжээ |
|---|-------------|-----------------|
| 1 | Тэмээ | 1000 |
| 2 | Адуу | 1000 |
| 3 | Үхэр | 1000 |
| 4 | Хонь | 1000 |
| 5 | Ямаа | 1000 |

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/165

Улаанбаатар
хот

СУУРЬ НОРМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.21, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төмөр замын салбарын гүүрийн барилгын ажилд шинэ технологи, ажилбар, машин механизм, тоног төхөөрөмж нэвтэрч байгаатай холбогдуулан Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх Авто замын салбарын дэд зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаартай зөвлөмж, Төмөр зам, далайн тээврийн салбарын дэд зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 04 дугаартай зөвлөмжийн дагуу техникийн баримт бичиг болох “Нэг замтай гүүрийн төмөрбетон дам нуруут алгаслыг тулгуур дээр байрлуулах” ажлын нормыг 1 дүгээр, “Гүүрийн төмөрбетон алгасал бүтцийг 10 метр хүртэл зайд хөндлөн шилжүүлэх” ажлын нормыг 2 дугаар, “Хогшлын инвентарийн бүтээцээр хийсэн ган вандан тавцан байгуулах” ажлын нормыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан нормын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), Төмөр замын газар (Б.Артур), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 6 дугаар сарын 11-ний
өдрийн А/165 дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлт*

**Нэр: Нэг замтай гүүрийн төмөрбетон дам нуруут алгаслыг
тулгуур дээр байрлуулах**
Хэмжих нэгж: **1 алгасал**

| Д/д | Ажлын бүрэлдэхүүн: |
|-----|--|
| 1 | Завсрын зам хязгаарлах өртөөнөөс краныг ажиллах газарт хүргэх ба буцаах |
| 2 | Дам нурууг оосорлон газар болон тулгуур дээр хөндлөн чиглэлд гулсуулж хөдөлгөх зам байгуулах |
| 3 | Дам нурууг краны суман дор болон тулгуур дээр хөндлөн чиглэлд хөдөлгөх |
| 4 | Алгасал бүтээц дээр кран хөдөлгөх түр төмөр зам байгуулах |
| 5 | Алгасал бүтээцийг оосорлож хөдөлгөж гулсуулах зам дээр байрлуулах |
| 6 | Дам нурууг тулгуур дээр хөндлөн хөдөлгөж тулах хэсэг дээр байрлуулах |
| 7 | Дам нуруунуудыг нэгтгэх |
| 8 | Гулсуулах болон кран явах зам бусад түр төхөөрөмжийг задлах |
| 9 | Дүүжин түр гүүр байгуулах, задлах |

Норм хэрэглэх заавар:

2 ширхэг дам нуруу бүхий 1 алгаслалын бүтээцийг тулгуур дээр байрлуулах ажлыг нормчлов.

Техникийн хэсэг:

Нэг гүүрэн дээр янз бүрийн урттай алгаслалын бүтээц кранаар угсрахад зардлыг хамгийн урт алгаслалын бүтээцийн нормоор тодорхойлно.

Тайлбар:

Энэхүү норм нь гүүрийн алгасал байгууламжийн дам нурууг тулгуур дээр тулгуурт кранаар шилжүүлж байрлуулах ажилд мөрдөгдөнө.

| Хөдөлмөр зарцуулалт | Зэрэг | Хүн цаг | |
|------------------------------|-------|-------------------|------|
| | | Алгаслалын урт, м | |
| | | 24 | 33 |
| Кальк 68-71 | I | 0.85 | 1.29 |
| | II | 10.2 | 10.3 |
| | III | 184 | 115 |
| | IV | 175 | 146 |
| | V | 122 | 121 |
| | VI | 44.8 | 26 |
| Талбайн зөөвөр тээвэр | | | |
| ЗТН-7 | II | 10.3 | 8.02 |

| Машин механизм | Хүчин чадал | Машин цаг | |
|--------------------------------------|-------------------|-------------------|------|
| | | Алгаслалын урт, м | |
| | | 24 | 33 |
| Тулгуурт кран | 80 тн | 12.2 | |
| Тулгуурт кран | 130 тн | 8.17 | 23.1 |
| Өргөн төмөр замын сэлгээний тепловоз | 883 квт (1200 мх) | 20.4 | 23.1 |
| Гидродомкрат | 100 тн | 99.4 | |
| Цахилгаан гагнуурын төхөөрөмж | 500А | 7.23 | 14.4 |

| Материалын нэр | | Хэмжих нэгж | Орц | |
|----------------|--|--------------------|-------------------|--------|
| | | | Алгаслалын урт, м | |
| | | | 24 | 33 |
| Т-III | Төмөрбетон алгаслалын бүтээц | шир/м ³ | 1/47.0 | 1/86.9 |
| I-589 | Хуучин зам төмөр төрөл III | тн | 1.78 | 0.77 |
| A 4164 | Тосолгоогүй шилмүүст дэр мод, төрөл III | шир | 50.1 | 24.4 |
| A 4147 | Дүнз, III зэрэг | м ³ | 0.92 | 1.05 |
| A 3976 | Захалсан банз, II зэрэг, 40-60 мм зузаан | м ³ | 0.73 | 0.44 |
| A 07017 | Хавтгай зузаан ган | тн | 0.05 | 0.19 |
| A 4043 | Гуалин мод, III зэрэг | м ³ | 0.51 | 0.54 |
| A 0096 | Хадаас | кг | 16 | 21.4 |
| A 0517 | Цуйдан | кг | 35 | 3.12 |
| A 0733 | Бөөрөнхий цувимал ган, 22 мм | кг | 47.5 | 63.4 |
| A 1599 | Төмөр замын хадаас | кг | 31.9 | 25.3 |
| A 0060 | Болт, гайка | кг | 1.76 | 2.44 |
| A 0733 | Арматур | кг | 3.2 | 6.4 |
| A 4198 | Бетон М400 | м ³ | 0.12 | 0.24 |

*Зам, тээврийн сайдын 2026 оны 6 дугаар сарын 11-ний
өдрийн А/165 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

**Нэр: Гүүрийн төмөр бетон алгасал бүтцийг 10 метр хүртэлх
зайд хөндлөн шилжүүлэх**

Хэмжих нэгж: Алгасал бүтцийн 1 ш дам нуруу

| Д/д | Ажлын бүрэлдэхүүн: |
|-----|--|
| 1 | Доод ба дээд гулсуулах зам байгуулах ба задалж буулгах |
| 2 | Өнхрүүлгийг байрлуулж алгаслалын бүтээцийн дам нурууг өнхрүүлэг дээр тавих |
| 3 | Дам нурууны дагууд дүнзээр ташуу тулаас хийх ба задалж авах |
| 4 | Дүүжин түр тавцанг байгуулах ба задалж буулгах |
| 5 | Домкратын тусламжтайгаар дам нурууг хөндлөн шилжүүлэх |
| 6 | Дам нурууг тулах хэсэг дээр байрлуулах |

Норм хэрэглэх заавар:

Энэхүү норм нь гүүрийн алгасал бүтцийн 1 ширхэг дам нурууг тулгуур дээр 10 метр хүртэлх зайд хөндлөн шилжүүлэх ажлыг нормчлов.

Техникийн хэсэг:

Нэг гүүрэн дээр янз бүрийн урттай алгаслалын бүтээц хөндлөн шилжүүлэх ажлын зардлыг хамгийн урт алгаслалын бүтээцийн нормоор тодорхойлно.

Тайлбар:

Хөндлөн шилжүүлэх зай 10 метрээс их бол ажлын тоо хэмжээг нэмэгдүүлж авна.

| Хөдөлмөр зарцуулалт | Зэрэг | Хүн цаг | |
|-----------------------|-------|-------------------|-------|
| | | Алгаслалын урт, м | |
| | | < 18 | >18 |
| Кальк №27 | II | 3.59 | 3.59 |
| | III | 93.2 | 93.2 |
| | IV | 99.4 | 108.5 |
| | V | 88.7 | 97.9 |
| | VI | 58.7 | 58.7 |
| Талбайн зөөвөр тээвэр | | | |
| ЗТН-7 | II | 5.3 | 6.37 |

| Машин механизм | Хүчин чадал | Машин цаг | |
|----------------|-------------|-------------------|----------|
| | | Алгаслалын урт, м | |
| | | < 18 | >18 |
| Гидродомкрат | 50 тн | 149/99.3 | 149/99.3 |

*Зам, тээврийн сайдын 2026 оны 6 дугаар сарын 11-ний
өдрийн А/165 дугаар тушаалын 3 дугаар хавсралт*

Нэр: Хогшлын инвентарийн бүтээцээр хийсэн ган вандан тавцан байгуулах

Хэмжих нэгж: 1 тн

| Д/д | Ажлын бүрэлдэхүүн: |
|-----|---|
| 1 | Угсралтын талбай байгуулах |
| 2 | Хийц бүтээцийг угсрах |
| 3 | Жаазыг босгож бэхлэх |
| 4 | Хөндлөн дам нуруу, шалавчийг тавьж хашлага байрлуулах |
| 5 | Металл хийцийг байрлуулах |
| 6 | Шалавч, хашлага болон хөндлөн дам нурууг задлах |
| 7 | Металл бүтээцийг гулдмай, маркаар нь ялгах |
| 8 | Угсармал металл хийцийг задлах |

Норм хэрэглэх заавар:

Энэхүү норм нь гүүрэн байгууламжийн өндөрт ажиллах хогшлын бүтээцээр хийсэн вандан тавцан байгуулах ажлыг нормчлов.

Техникийн хэсэг:

Угсрах ган хийцийг иж бүрдлийн бус ган бүтэц нэмж түр гүүр байгуулахад угсрах, задлах зардлыг нормоор тодорхойлоход ган бүтээцийн нийлбэр жинг авч үзнэ.

Тайлбар:

Ажлын хэмжих нэгжийг 1 тн гэж өгөгдсөн ба зураг төслийн байгууллагуудын боловсруулсан барилга угсралтын ажлын зургийн дагуу гүүрийн овор хэмжээнд тааруулан ажлын тоо хэмжээнд тусгаж өгнө.

| Хөдөлмөр зарцуулалт | Зэрэг | Хүн цаг | | |
|------------------------------|-------|-----------------|------|--------|
| | | Угсрах өндөр, м | | Задлах |
| | | <12 | >12 | |
| Кальк 51, 52 | I | 33.4 | 2.9 | 5.04 |
| | II | 31.9 | 33.8 | 6.13 |
| | III | 8.66 | 2.82 | 3.52 |
| | IV | 5.17 | 5.48 | 2.41 |
| | V | 0.25 | 0.25 | |
| | VI | 49.3 | 51.2 | 17.1 |
| Талбайн зөөвөр тээвэр | | | | |
| ЗТН-58 | II | 0.04 | 0.03 | |

| Машин механизм | Хүчин чадал | Машин цаг | | |
|-------------------------------|-------------|-----------------|------|--------|
| | | Угсрах өндөр, м | | Задлах |
| | | <12 | >12 | |
| Гинжит кран | 30 тн | 3.09 | 3.44 | 2.18 |
| Цахилгаан гагнуурын төхөөрөмж | 500А | 0.82 | 0.71 | |
| Авто машин | 4 хүн | | | 0.12 |

| Материалын нэр | | Хэмжих нэгж | Орц | |
|-----------------|---|-------------|-----------------|--------|
| | | | Угсрах өндөр, м | |
| | | | <12 | >12 |
| А 4164 | Вандангийн хогшлын ба хогшлын бус ган бүтээцүүд: | тн | 1x0.22 | 1x0.22 |
| | Зам гүүр ба бусад барилга байгууламжийн зориулалттай шилмүүст бөөрөнхий мод | м³ | 0.04 | 0.04 |
| | Шилмүүст бөөрөнхий мод, II зэрэг, диаметр 16 см | м³ | 0.06 | 0.05 |
| | Мөн III зэрэг, диаметр 20 см | м³ | 0.023 | 0.02 |
| | Дүнз ба дүнзэнцэр, III зэрэг, > 70 мм | м³ | 0.002 | 0.002 |
| | Банз, III зэрэг, 40-60 мм | м³ | 0.12 | 0.12 |
| | Барилгын ердийн бэхэлгээ 1.6 кг хүртэл жинтэй | кг | 16.2 | 16.5 |
| | Төмөр замын тосолгоогүй шилмүүст дэр мод, III төрөл | шир | 1.1 | 1.14 |
| | Электрод | кг | 2.3 | 2.0 |
| | Боолт | кг | 4.48 | 3.89 |
| Барилгын хадаас | кг | 3.04 | 2.88 | |

ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар А/93

Улаанбаатар
хот

ТОДОРХОЙЛОЛТ, НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 28.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Отгонцэцэг)-т даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт батлах тухай” 2022 оны А/547 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

*Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны
6 дугаар сарын 02-ны өдрийн А/93 дугаар тушаалын хавсралт*

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЗЭРЭГ ДЭВИЙН ТОДОРХОЙЛОЛТ, НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт:

Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан эрдэм, шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт байна.

2.Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт:

а)Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.Докторын /Ph.D/ зэрэгтэй, докторын зэрэг хамгаалснаас хойш судалгааны чиглэлээрээ 6-аас доошгүй жил ажилласан байх;

2.Судалгааны шинэ чиглэл санаачлах, хэрэгжүүлэх чадавхтай (Олон улсын болон үндэсний судалгааны тэтгэлэг, төсөл хэрэгжүүлж, гэрээт захиалгат ажил гүйцэтгэн байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн), эрдэм шинжилгээний байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх (шинэ тоног төхөөрөмжийг олон улс, хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэсэн г.м);

3.Өөрийн судалгааны мэргэшсэн чиглэлээр 3-аас доошгүй судлаачийг бэлтгэсэн, эрдэм шинжилгээний ажилтныг шинэ мэдээллээр хангах, дадлагажуулах, тэднийг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах чиглэлээр ажилласан байх;

4.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдад үлгэр жишээ үзүүлдэг, манлайлах, багаар ажиллах чадвартай байх;

5.Оюуны өмч (зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрх) авсан эсвэл нэг сэдэвт бүтээл нийтлүүлсэн байх;

6.“Scopus” эсвэл “Web of Science”-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл, номын бүлэг хэвлүүлсэн, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байх;

7.Гадаад хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн.

б)Эрдэм шинжилгээний ахлах ажилтан дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.Докторын зэрэгтэй, докторын зэрэг хамгаалснаас хойш судалгааны чиглэлээрээ ажилласан;

2.Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил, эрдэм

шинжилгээний бага хурал, семинар, хээрийн судалгааг удирдах, судалгаа шинжилгээний ажилд дүгнэлт хийх арга барил эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;

3.Өөрийн судалгааны мэргэшсэн чиглэлээр 2-оос доошгүй судлаачийг бэлтгэсэн, эрдэм шинжилгээний ажилтныг шинэ мэдээллээр хангах, дадлагажуулах, тэднийг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах чиглэлээр ажилласан байх;

4.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдад үлгэр жишээ үзүүлдэг, манлайлах, багаар ажилладаг чадвартай;

5.“Scopus” эсвэл “Web of Science”-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байх;

6.Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программуудыг эзэмшсэн;

7.Гадаад хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн;

в)Эрдэм шинжилгээний дэд ажилтан дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.Магистраас доошгүй зэрэгтэй;

2.Шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх арга зүй эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;

3.Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программуудыг эзэмшсэн;

4.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг;

5.Судалгааны чиглэлээрээ сүүлийн 4 жил ажилласан;

6.Гадаад хэлийг өөрийн судалгааны чиглэлийн түвшинд эзэмшсэн.

г)Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.Бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй;

2.Өөрийн судалгааны ажлын чиглэлээр арга зүй эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;

3.Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программыг эзэмшсэн;

4.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг;

5.Гадаад хэлний зохих мэдлэг эзэмшсэн.

3.Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт:

| Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэв | Шалгуур үзүүлэлт |
|--------------------------------------|--|
| Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан | <ul style="list-style-type: none"> • “Scopus” эсвэл “Web of Science”-д бүртгэлтэй, импакт фактортой эрдэм шинжилгээний сэтгүүлд 2-оос доошгүй өгүүллийг нэгдүгээр болон холбоо баригч зохиогчоор, дотоодын эрдэм шинжилгээний тогтмол хэвлэгддэг сэтгүүлд 6-оос доошгүй өгүүлэл хэвлүүлсэн; • Олон улсын хуралд 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 4-өөс доошгүй илтгэл хэлэлцүүлж, хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн; • Зохиогч, хамтран зохиогчоор ажилласан нэг сэдэвт бүтээл, хамтын бүтээл, ном, эмхэтгэл, сурах бичгийн тоо, сэдэвчилсэн зураг 3-аас доошгүй, эсвэл гадаад болон дотоодод хамгаалсан патент, ашигтай загвар, гарган авсан инновацын бүтээгдэхүүн (сорт, үүлдэр), практикт нэвтэрсэн үйлчилгээ, ТЭЗҮ, программ хангамж 1-ээс багагүй байх; • Эрдэм шинжилгээний бүтээлээс нь дотоод, гадаадын судлаачдын авсан эшлэлийн тоо 25-аас доошгүй байх; • Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 6-аас доошгүй нийтлэл, ярилцлага өгсөн; • Доктор 1 эсвэл магистрын ажил 2-оос доошгүй удирдаж хамгаалуулсан, 2-оос доошгүй шүүмж бичсэн; • Удирдсан, гүйцэтгэсэн төсөлт ажлын тоо 3-аас доошгүй байх; • Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын баталгаажуулсан арга зүй, тайлан 2-оос доошгүй; • Гадаад хэлний мэдлэгтэй байх. |
| Эрдэм шинжилгээний ахлах ажилтан | <ul style="list-style-type: none"> • “Scopus” эсвэл “Web of Science”-д бүртгэлтэй, импакт фактортой эрдэм шинжилгээний сэтгүүлд 1-ээс доошгүй өгүүллийг нэгдүгээр болон холбоо баригч зохиогчоор, хянан магадалгаа хийгддэг олон улсын сэтгүүлд 2-оос доошгүй, дотоодын эрдэм шинжилгээний тогтмол хэвлэгддэг сэтгүүлд 4-өөс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн; • Олон улсын хуралд 2-оос доошгүй илтгэл хэлэлцүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлж, хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн; • Зохиогч, хамтран зохиогчоор ажилласан нэг сэдэвт бүтээл, хамтын бүтээл, ном, эмхэтгэл, сурах бичгийн тоо, сэдэвчилсэн зураг 2-оос доошгүй, эсхүл гадаад болон дотоодод хамгаалсан патент, ашигтай загвар барааны тэмдэгт гарган авсан инновацын бүтээгдэхүүн (сорт, үүлдэр), практикт нэвтэрсэн үйлчилгээ, ТЭЗҮ программ хангамж 1-ээс багагүй байх; • Эрдэм шинжилгээний бүтээлээс нь дотоод, гадаадын судлаачдын авсан эшлэлийн тоо 15-аас доошгүй байх; • Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 4-өөс доошгүй нийтлэл, ярилцлага өгсөн; • Магистрын ажил 1-ээс доошгүй удирдсан, 2-оос доошгүй шүүмж бичсэн; • Удирдсан, гүйцэтгэсэн төсөлт ажлын тоо 2-оос доошгүй байх; • Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын баталгаажуулсан арга зүй, тайлан 1-ээс доошгүй; • Гадаад хэлний мэдлэгтэй байх. |

| | |
|---|---|
| <p>Эрдэм шинжилгээний дэд ажилтан</p> | <ul style="list-style-type: none"> • Импакт фактортой эрдэм шинжилгээний сэтгүүлд 1-ээс доошгүй, дотоодын эрдэм шинжилгээний тогтмол хэвлэгддэг сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл хэвлүүлсэн; • Олон улсын хуралд 1-ээс доошгүй илтгэл хэлэлцүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 2-оос доошгүй илтгэл хэлэлцүүлж, хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн; • Зохиогч, хамтран зохиогчоор ажилласан нэг сэдэвт бүтээл, хамтын бүтээл, ном, эмхэтгэл, сурах бичиг, сэдэвчилсэн зураг, гарын авлагын тоо 1-ээс доошгүй, эсхүл гадаад болон дотоодод хамгаалсан патент, гарган авсан инновацын бүтээгдэхүүн, практикт нэвтэрсэн үйлчилгээ, ТЭЗҮ, программ хангамж 1-ээс багагүй байх; • Эрдэм шинжилгээний бүтээлээс нь дотоод, гадаадын судлаачдын авсан эшлэлийн тоо 5-аас доошгүй байх (өөрийн бүтээлээс авсан эшлэлийг оруулахгүйгээр); • Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2-оос доошгүй нийтлэл, ярилцлага өгсөн байх; • 2-оос доошгүй хээрийн судалгаа, лабораторийн ажил, социологи, бодлогын болон хамтарсан судалгаанд хамтран болон бие даан гүйцэтгэсэн байх, оролцсон байх; • Гүйцэтгэсэн төсөлт ажлын тоо 1-ээс доошгүй байх; • Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын оролцсон арга зүй, тайлан 1-ээс доошгүй; • Гадаад хэлний мэдлэгтэй байх. |
| <p>Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан</p> | <ul style="list-style-type: none"> • Зохиогч, хамтран зохиогчоор ажиллаж, хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний 2-оос доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байх; • Эрдэм шинжилгээний хуралд 2-оос доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх; • Захиалгат, гэрээт, төсөл болон бусад салбарын мэргэжлийн 1-ээс доошгүй эрдэм шинжилгээний ажилд гүйцэтгэсэн, оролцсон байх; • Гадаад хэлний мэдлэгтэй байх. |

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/196

Улаанбаатар
хот

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журмыг нэгдүгээр, тусламж, үйлчилгээний жагсаалтыг хоёрдугаар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх шалгуурыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д даалгасугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 1993 оны А/180 дугаар тушаал, 2023 оны А/283 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Э.БАТШУГАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар А/237

Хэрлэн
сум

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 74 дүгээр зүйлийн 74.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 22 дугаар зүйлийн 22, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг батлах тухай”, 2024 оны А/458 дугаар “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Захирамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Захиргааны хэм хэмжээний акт улсын нэгдсэн санд бүртгүүлж, олон нийтэд сурталчлан таниулж ажиллахыг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Батхүү), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Баярхүү)-т тус тус даалгасугай.

3.Эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн ажиллах цагийн хязгаарт хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Д.Хатанбаатар), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/194 дүгээр “Цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУНБУНЬ

**Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны
5 дугаар сарын 15-ны өдрийн
А/237 дугаар захирамжийн хавсралт**

| Д/д | Тусгай зөвшөөрлийн төрөл | Цагийн хязгаар | |
|---|--|--|--|
| | | Дулааны улирал | Хүйтний улирал |
| | | Жил бүрийн 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр | Жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр |
| 1. | Согтууруулах ундаа худалдах | 07 ⁰⁰ -00 ⁰⁰ | |
| 2. | Согтууруулах ундаагаар үйлчлэх /Аж ахуйн нэгжийн сонголтоор/ | 11 ⁰⁰ -22 ⁰⁰ | |
| | | 14 ⁰⁰ -04 ⁰⁰ | 14 ⁰⁰ -01 ⁰⁰ |
| Жил бүр дараах өдрүүдэд тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь зөвхөн 18 хүртэлх хувийн хатуулгатай этилийн спирт агуулсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилнэ. | | | |
| 1. | Хичээлийн шинэ жилийн нээлт | 09 дүгээр сарын 01 | |
| 2. | Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр | 06 дугаар сарын 01 | |

УВС АЙМАГ ХОВД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 7/8

Хөх толгой

ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дүгээр зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Хог хаягдлын үйлчилгээний хураамж шинэчлэн тогтоох тухай” сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 30-ний 8/11 дэх тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Сумын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийн хэмжээ”-г дор дурдсан агуулга бүхий дараах заалтыг нэмсүгэй.

| Д/д | Хог хаягдлын эх үүсвэр | Тооцох нэгж | Үйлчилгээний хураамж / төгрөг/ |
|-----|------------------------|-------------|--------------------------------|
| 1 | Иргэн | Сар бүр | 500 |

2.Дээрх нэмэлт орсонтой холбогдуулан “Сумын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийн хэмжээ”-ний 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3.Хог хаягдлын үйлчилгээний хураамж, үнэ тарифыг аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд мөрдүүлж, тогтоолын хэрэгжилтийг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Э.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын өөрчлөлтийг хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Хууль эрх зүй, хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн (Д.Одончимэг)-д даалгасугай.

ДАРГА

Х.БАТСУУРЬ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 5 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

“ДОМЭЙН НЭРИЙГ БҮРТГЭХ, АШИГЛАХ ЖУРАМ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 242 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4¹ дэх хэсэгт “Гэрээт бүртгэгч нь Бүртгэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр энэ журмын 4.4 дэх хэсэгт зааснаас бусад Дэд домэйн нэрийг бүртгэж болно.” гэж, журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Дэд домэйн нэрийн ангилал”-д:

| | | |
|----|---|--|
| me | Хувь хүн, брэндийн цахим оршихуй | Монгол Улсад оршин суугаа хаяг, бүртгэлтэй хүн |
| ub | Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага | Улаанбаатар хотод оршин суугаа хаяг, бүртгэлтэй хуулийн этгээд |

гэж, журмын 3 дугаар хавсралт “Домэйн нэрийн бүртгэлийн ангилал”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар тус тус нэмсүгэй.

2.Журмын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсгийг “Бүртгэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг Гэрээт бүртгэгч гэж нэрлэнэ.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийг “Домэйн нэр бүртгэгч нь домэйн нэрийг Хавсралт 3-т заасан үйл ажиллагааны чиглэл, эзэмшигчийн төрлөөр ангилж бүртгэнэ.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3.Журмын 6 дугаар зүйлийн 6.1.8, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

М.БАТТУЛГА
Ч.ЗОЛБАЯР
Б.МЯГМАРНАРАН
С.ТАМИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн
56 тоот тогтоолын хавсралт*

ДОМЭЙН НЭРИЙН БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ

| | |
|---------------------------|------------------------------------|
| Үйл ажиллагааны чиглэлээр | Цахим худалдаа |
| | Цахим тоглоом |
| | Санхүү, эдийн засаг |
| | Мэдээ мэдээлэл |
| | Харилцаа холбоо, өргөн нэвтрүүлэг |
| | Боловсрол |
| | Шинжлэх ухаан, танин мэдэхүй |
| | Байгаль орчин, аялал жуулчлал |
| | Улс төр |
| | Хөдөө аж ахуй |
| | Эрүүл мэнд |
| | Хүмүүнлэг, халамж, нийгмийн чиглэл |
| | Спорт, соёл урлаг |
| Бусад | |
| Эзэмшигчийн төрлөөр | Төрийн байгууллага |
| | Төрийн бус байгууллага |
| | Олон улсын байгууллага |
| | Аж ахуйн нэгж, байгууллага |
| | Иргэн |

Тайлбар:

- “Төрийн бус байгууллага” гэж Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4.1 дэх хэсэгт: заасны дагуу иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг ойлгоно. Гадаадын төрийн бус байгууллага хамаарахгүй.
- “Олон улсын байгууллага” гэж Олон улсын гэрээний тухай хуулийн 3.1.6.-д заасны дагуу Улс болон Засгийн газар хоорондын түвшинд байгуулагдсан олон улсын байгууллага, тэдгээртэй адилтгах зохион байгуулалтын бусад нэгдлийг ойлгоно. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага (компани) хамаарахгүй.

- “Аж ахуйн нэгж ” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-т заасны дагуу улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг ойлгоно.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар А/150, 370

Улаанбаатар
хот

АРГАЧЛАЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.1, 6.1.2 дахь заалт, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 79 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-д доор дурдсан агуулгатай 2.4-2.6 дахь хэсгүүдийг нэмсүгэй:

“2.4. Банк нь зээлдэгч аж ахуйн нэгжид санал болгох жишиг суурь хүүгийн дээд болон доод түвшинг зээлийн эрсдэлийн түвшин, эргэн төлөгдөх чадвар, бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцож, олон нийтэд зарлана.

2.5. Банк жишиг суурь хүүг жилийн хувиар илэрхийлж, улирал бүр шинэчлэн мэдээлэх ба өөрчлөлт орсон тухай бүрд үнэн зөв тооцож, өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.

2.6. Банк жишиг суурь хүүг жилийн хувиар илэрхийлж, гуравдугаар хавсралтын дагуу улирал бүрийн эхэнд болон өөрчлөлт орсон тухай бүрд үнэн зөв тооцон баталгаажуулна.”

2. “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ын 3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.2 Банк мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэл, хураамж болон жишиг суурь хүүгийн нөхцөлдөө өөрчлөлт оруулсан тохиолдолд ажлын 1 өдөрт багтаан мэдээллээ шинэчилнэ.

3. “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-д “Зээлийн жилийн жишиг суурь хүү тооцох загвар” гэсэн гуравдугаар хавсралт нэмсүгэй.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Банкны хяналт шалгалтын газар (Ц. Дамдинсүрэн)-т, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (С.Цогтгэрэл)-д тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

“Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал” -ын 3 дугаар хавсралт

ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ЖИШИГ СУУРЬ ХҮҮ ТООЦОХ ЗАГВАР

Зээлийн жилийн жишиг суурь хүү *(Аж ахуйн нэгжийн хувьд)*

1. Олон нийтэд зарлах зээлийн жишиг суурь хүү:

20... оны ... дугаар улирлын байдлаар

(доод түвшин) – (дээд түвшин) хувь (2 орны нарийвчлалтай)

2. Жишиг суурь хүү тооцох аргачлал (банк дотооддоо тооцох) Үүнд:

| Д/д | Жишиг суурь хүү тооцох бүрэлдэхүүн хэсэг | Жишиг суурь хүүг бүрдүүлж байгаа нэгж хувь* | Жишиг суурь хүүгийн утгад эзлэх хувийн жин |
|------------|---|--|---|
| 1. | Эх үүсвэрийн зардал | % | % |
| 2. | Хөрвөх чадварын эрсдэлийн тохируулга | % | % |
| 3. | Үйл ажиллагааны зардал | % | % |
| 4. | Татварын зардал | % | % |
| 5. | Бусад | % | % |
| | Жишиг суурь хүү | % | 100.0 % |

* - 2 орны нарийвчлалтай

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар А/147

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.12 дахь заалт тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/271 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журам”-д хавсралт ёсоор нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулатын газар (Х.Илтгэлт)-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 28-ны
өдрийн А/147 дугаар тушаалын хавсралт*

**“МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХ,
БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ”-Д ОРОХ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ**

1. “Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журам”-д дараах заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 2.5. Шаардлагатай тохиолдолд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тодорхой хугацаанд хэсэгчлэн хязгаарлалт хийж болно.

2/ 3.4. Төмөр замын тээврийн байгууллага нь энэхүү журмын 3.3-т заасан ажлын хэсэг томилсон тушаалыг үндэслэн, холбогдох баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш 10 ажлын өдрийн дотор зэргэлдээ төмөр замын байгууллагад хөдлөх бүрэлдэхүүн хүлээн авахтай холбоотой цахилгаан мэдээг хүргүүлнэ.

3/ 4.11. Энэхүү журмын хавсралтаар батлагдсан хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээг, журмын 3.3-т заасан ажлын хэсгээс гарсан дүгнэлт болон холбогдох баримт бичгийг үндэслэн төрийн захиргааны байгууллага олгоно.

4/ 4.12. Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ нь үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацаагаар олгоно.

2. Мөн журмын “2.1.4” дахь заалтын “вагоны” гэснийг “хөдлөх бүрэлдхүүний” гэж, “2.4” дахь заалтын “журмын 2.6-т” гэснийг “журмын 2.3-т” гэж, “3.6”, “3.7”, “4.2” дахь заалтуудын “3.3-т заасан” гэснийг “3.3-т заасан ажлын хэсгээс гарсан” гэж, “4.1” дахь заалтын “бүртгэл хөтлөх, дугаар олгох, хөдлөх бүрэлдхүүний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” гэснийг “улсын бүртгэлд бүртгэх, дугаар олгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах” гэж, “4.3” дахь заалтын “Хилээр хөдлөх бүрэлдхүүнийг Монгол Улсад түрээсээр ашиглах зорилгоор” гэснийг “Санхүүгийн түрээсээр ашиглах зорилгоор хөдлөх бүрэлдхүүнийг хилээр” гэж, 2.6 заалтын дугаарлалтыг 2.3 гэж, 2.7 заалтын дугаарлалтыг 2.4 гэж, 3.4 заалтын дугаарлалтыг 3.5 гэж, 3.5 заалтын дугаарлалтыг 3.6 гэж, 3.6 заалтын дугаарлалтыг 3.7 гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн журмын 2.3, 2.4, 2.5, 3.2.8, 3.2.9, 3.7 дахь заалтыг тус тус хассугай.

*“Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх,
гэрчилгээ олгох журам”-ын хавсралт*

- Монгол Улсын хилээр нэвтэрч, улсын бүртгэлд бүртгүүлсэн хөдлөх бүрэлдэхүүнд гэрчилгээ олгоно.
- Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ нь А5 хэмжээтэй хээтэй хүрээ бүхий үнэт цаасан дээр хэвлэнэ.

| | |
|--|-----------------|
| <i>Нүүр</i> | |
| <i>ТӨРИЙН СОЁМБО</i> | |
| ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ТӨМӨР ЗАМЫН ГАЗАР GOVERNMENT IMPLEMENTING AGENCY RAILWAY AUTHORITY OF MONGOLIA | |
| ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ГЭРЧИЛГЭЭ ROLLING STOCK CERTIFICATE | |
| Гэрчилгээний № <i>Certificate ID:</i> | РД: |
| Өмчлөгчийн нэр: | |
| <i>Owner's name:</i> | |
| Өмчлөгчийн код: | |
| <i>Owner's code:</i> | |
| Нэр төрөл: | |
| <i>Type of rolling stock:</i> | |
| Хөдлөх бүрэлдэхүүний дугаар: | |
| <i>Rolling stock No:</i> | |
| Үйлдвэрлэсэн он сар: | |
| <i>Date of manufacture:</i> | |
| Импортоор орж ирсэн он сар: | |
| <i>Date of import:</i> | |
| Гэрчилгээ олгосон огноо: | |
| <i>Certificate date of issue:</i> | |
| Гэрчилгээ дуусах огноо: | |
| <i>Certificate date of expiry:</i> | |
| ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГА /ГАРЫН ҮСЭГ/ | ОВОГ.НЭР |
| ТАМГА | |

Арын хэсэг

ӨӨРЧИЛСӨН ТЭМДЭГЛЭЛ

| № | Төрөл, зориулалт | Тайлбар |
|---|------------------|---------|
| 1 | | |

Санамж:

- Шинээр хөдлөх бүрэлдэхүүн худалдсан бол 14 хоногийн дотор;
- Акталсан, осолд орсон, ашиглалтын норм хугацаа дууссан бол 1 сарын дотор;
- Хөдлөх бүрэлдэхүүнд өөрчлөн тоноглол хийсэн бол 30 хоногийн дотор;
- Гэрчилгээний хугацаа дууссан, хаяж үрэгдүүлсэн бол 14 хоногийн дотор тус тус мэдээллийн санд өөрчлөлт оруулж, бүртгэлийг шинэчлэх, шинээр гэрчилгээ авна уу.

*Цахим хуулбар
харах холбоос
QR код
Хэмжээ 30x30мм*

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 129 дүгээр тушаал нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон ...” гэж заасан шаардлагыг хангахгүй болсон байх тул хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд холбогдох хөдөлгөөн хийлгэх арга хэмжээг авч ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргилд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Н.НОМТОЙБАЯР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар А/110

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/148 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Хүчингүй болсон тушаалыг холбогдох журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах арга хэмжээ авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Идэр)-т даалгасугай.

САЙД

Т.АУБАКИР

